



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ
ФОРУМ



НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ
ХҮРЭЭЛЭН

**Хэвлэл мэдээллийн
эрх чөлөөний**

2007

ТАЙЛАН



ГЛОБ ИНТЕРНЭШНЛ ТББ

Улаанбаатар хот
2008 он

Бэлтгэсэн:

Х. Наранжаргал
Д. Мөнхбүрэн
Г. Даваахүү
Б. Насанжаргал
М. Амартүвшин
С.Баяраа
Р.Мөнх-Очир
Ж.Энхтуул
А.Бямбасүрэн
Х.Саранчимэг

Ш.Цоодол
И.Байгалмаа
Ж.Мөнх-Очир
Ө.Рагчаасүрэн
А.Отгончимэг
О.Алтансүх
Т.Цэрэндулам
Ю.Гэрэлтуяа
Ж.Алтанцэцэг
О.Амарзаяа
Г.Сүхээ

А.Наранболд
Ч.Уранцэнгэл
Ч.Отгонцэцэг
Х.Айнур
Л.Эрдэнэбат
Ж.Энхбаатар
П.Отгонтуяа
С.Хунчин

Хаяг: Соёлын Төв өргөө, Г корпус, 3-р давхар
Улаанбаатар 210620-А, ш/х-28

Утас: /976-11/ 324764
/976-11/ 324627

И-мэйл: globe@magicnet.mn

Вэб сайт: www.globeinter.org.mn
www.monitoring.mn

“Чөлөөт Хэвлэл Сан” СХҮ-т эхийг бэлтгэж, хэвлэв.

*Нээлттэй Нийгэм форум, Лондон дахь Нээлттэй Нийгэм
хүрээлэнгийн хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөрийн
санхүүжилтээр хэрэгжүүлсэн “Үзэл бодлоо илэрхийлэх
эрх чөлөөний зөрчлийн мониторинг ба хараат бус хэвлэл
мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийн хүрээнд “Глоб
Интернэшнл” ТББ-аас бэлтгэн гаргав.*



Гэрэл зургийн сурвалжлагч



Гарчиг

Оршил	5
Нэг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа	7
1.1 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хэвлэл мэдээлэл	7
1.2 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт	10
1.3 Мэдээллийн эрх чөлөө	14
1.4 Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах нь	14
1.5 Хэвлэл мэдээллийн өмчлөл	15
Хоёр. Хараат бус хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эрхийн зөрчил	16
2.1 Сэтгүүлчийн хувийн аюулгүй байдал	17
2.2 Сэтгүүлчдийн эсрэг дайралт	17
2.3 Мэдээлэл өгөхөөс татгалзах нь	21
2.4 Эх сурвалжаа илчлэхийг шаардах нь	22
2.5 Нэр төр, алдар хүнд, гүтгэлэг, доромжлолтой холбоотой хуулийг ашиглаж буй нь	23
Гурав. Хэвлэл мэдээллийн өмчлөл	27
Дөрөв. Төрийн нууц мэдээлэл	30
Тав. Монголын хэвлэл мэдээллийн салбар дахь анхны өлсгөлөн	32
Зургаа. Дүгнэлт, цаашид яах вэ?	33
Хавсралт	35

Оршил

Бид 2006 онд анх удаа Монгол дахь хэвлэлийн эрх чөлөөний тайлан бэлтгэж, та бүхэнд толилуулсан билээ. Энэ удаа хоёр дахь тайлангаа өргөн барьж буйдаа баяртай байна.

Энэ ялдамд эдгээр тайланг бэлтгэх боломж олгосон Нээлттэй Нийгэм Форум (ННФ), Нээлттэй Нийгэм Хүрээлэн (ННХ)–гийн Хэвлэл мэдээллийн бүсийн хөтөлбөрт талархал илэрхийлье.

Энэ тайлан нь Монголын сэтгүүлчид мэргэжлийн эрхээ хэрхэн эдэлж буй, тэдний олон нийтийн өмнө хүлээсэн үүрэг, хариуцлагаа шударгаар биелүүлэх боломж нь аль хэр байгааг баримтад тулгуурлан монголын хэвлэлийн эрх чөлөөний өнөөгийн дүр төрхийг харуулах зорилготой юм.

Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, ялангуяа хэвлэлийн эрх чөлөө нь ардчилсан нийгмийн салшгүй хэсэг юм. Чөлөөт, хараат бус хэвлэл мэдээлэл бол улс төрч, эрх баригчдаас ард түмэнд өгч буй бэлэг биш. Харин ардчилсан нийгэмд амьдарч буй хүний суурь эрхийн нэг билээ.

Хараат бус хэвлэл мэдээллийн улс төр, эдийн засаг, эрх зүйн таатай орчинг хэрхэн бүрдүүлж буй нь төрөөс иргэндээ үйлчлэх үүргийн биелэлтийн хэмжүүр болдог. Ардчилсан нийгэмд хэвлэл мэдээлэл, сэтгүүлчид төр, түүний эрх баригчдад бус олон түмэнд үйлчилж, нийгмийн хоточ нохой байж, эрх мэдлийг хянах үүрэг гүйцэтгэдэг.

Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөөг хамгаалсан нааштай хууль тогтоомж байгаа хэдий ч амьдрал дээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчдийн мэргэжлийн эрх зөрчигдсөөр байна. Энэ нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж, сэтгүүлчид үнэн мэдээлэл түгээж чадахгүйд хүрч, ардчилал, нийгмийн эрх ашигт бодитой хор хохирол учруулж буй юм. Манайд цагдан хяналт (цензур)–ыг хуулиар хориглосон ч ил болон далд хэлбэрээр байсаар байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоож, сэтгүүлчдийг өөртөө үйлчлэхийг шаардах нь ардчиллын мөн чанар, хэм хэмжээ, зарчмаас гадуур үл тэвчиж болох үйлдэл юм.

ЮНЕСКО–гийн Бээжин дэх салбарын Харилцаа холбоо, Мэдээллийн хөтөлбөрийн захиалгаар 2006 оны 9–р сард Монголын хэвлэл мэдээллийн салбарын төлөв байдалд хийсэн задлан шинжилгээний тайланд “Коммунист дэглэмийг халснаас хойш үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний байдал мэдэгдэхүйц сайжирсан ч, хэвлэлийнхний бие эрхтэн, эрүүл мэндэд халдах, заналхийлэх, нэр төр гутаасан хэрэгт буруутгах, санхүүгийн дарамт шахалт үзүүлэх, хууль бус хязгаарлалт тогтоох зэрэг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчил Монголд өнөө хэр гарсаар байна. Ийм зөрчил үндэсний хэмжээний хэвлэл мэдээллийн байгууллагад ч, орон нутгийнханд ч тохиолдож байна. Эдгээр зөрчил нь өөрөө тулгамдсан бэрхшээл төдийгүй, хэвлэл мэдээллийн улс төр, санхүүгийн хараат байдалд хамааралтайгаараа бүр ч ноцтой асуудал юм. ХМХ, сэтгүүлчид нь улс төр, бизнесийн санхүүгийн дэмжлэгээс туйлын хараат болжээ. Үндэсний хэмжээний ихэнх ХМХ ашиг орлоготой хэвлэл мэдээллийн бизнес байх нь ховор, харин улс төр, бизнесийн ашиг сонирхлыг эн тэргүүнд тавьж, тэдэнд үйлчилдэг суртал ухуулгын дуу хоолой болжээ” гэсэн дүгнэлт хийжээ.

Улс төрч, албан тушаалтан, албан хаагчид Эрүүгийн хууль, Иргэний хуулийн нэр төр, алдар хүнд, гүтгэлэг доромжлолтой холбоотой заалтуудыг цензур болгон ашиглах нь түгээмэл байна. Монголын шүүх ийм хэргийг шийдвэрлэхдээ олон нийтийн үнэн мэдээлэлтэй байх хууль ёсны эрх ашгийг нь авч үзэлгүй өрөөсгөл хандаж байгаа нь шүүхийн шударга, хараат бус байдалд эргэлзээ төрүүлж байна. Эрх баригчид өөрийн эрх мэдэл, албан тушаалыг ашиглан шударга

шүүмжлэлийг няцаах, өөрсдийн буруутай үйлдлийг ард иргэдээс нуун дарагдуулахын тулд үнэн мэдээллийг саармагжуулах хүсэлтэй байдаг.

Монголын сэтгүүлчид өнөө хэр төрийн байгууллага, албан тушаалтан, албан хаагчдаас мэдээлэл олж авч чадахгүй, төрийн байгууллагын бичиг баримтыг олж үзэх боломжгүй байгаа нь төрийн байгууллагын олон нийтэд ил тод, нээлттэй байх ёстой ардчилсан зарчим алдагдаж, иргэдийн үнэн мэдээлэл олж авах эрх хөсөрдөхөд хүргэж байна. Энгийн мэдээлэл олж авах төдийд эрх нь зөрчигдөж буй сэтгүүлчид далд нуугдмал буй мэдээлэл, баримт мэдээг эрэн сурвалжилж олон түмэнд мэдээлэхэд туйлын хүндрэлтэй байгааг илтгэж байна.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл нийтэд ил тод бус байгаа нь олон ургальч үзлийг хөхиүлэн дэмжих бус, харин тэдгээрийн далд эздийн үзэл бодол, нэг талыг барьж туйлширсан мэдээллээ олон түмэнд тулган нийгмийг төөрөгдүүлэн будилахад хүргэж байна. Монголын олон нийт хэн нь үнэн ярьж байгааг ойлгохоо байж, хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдэд итгэл алдрах нь нийгмийн шударга ёсыг уламдаа гишгиж буй хэрэг юм.

Сэтгүүлчид янз бүрийн дарамт шахалт дор эх сурвалжаа илчлэх нь мэдээлэгчдийн аюулгүй байдалд ноцтой хор учруулах төдийгүй хэвлэл мэдээлэл ард иргэдийн өмнө хүлээсэн хяналтын үүргээ хөсөрдүүлэхэд хүргэнэ. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ач холбогдол, үнэ цэнэ алга болбол нийгэм хэзээ ч цэвэршиж, ариусахгүй.

Үнэнийг хэлэх гэсэн, хэлснийх нь төлөө сэтгүүлчдийг дайрч давшлах, далайлган сүрдүүлэх, айлган заналхийлэх, өмч хөрөнгө, бие эрхтэнд халдах нь хэрхэвч байж болохгүй ноцтой үйлдэл, гэмт хэрэг юм. Монголын цагдаа, шүүх буруутныг илрүүлэн үнэн мөнийг тогтоож, хариуцлага хүлээлгэх үүргээ зохих ёсоор биелүүлж чадахгүй байгаа нь харамсалтай.

Тайлан үндсэн хоёр бүлэгтэй. Эхний бүлэгт иргэдийн үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний баталгаа, мөн түүнийг хязгаарлаж буй хууль тогтоомжийн тухай мэдээллийг оруулсан болно.

Тайлангийн II бүлэгт сэтгүүлчдийн эрхийн зөрчлийн тухай жишээ баримтаас тусгав. Эдгээр нь 2005 оны 10-р сараас ННФ, ННХ-гийн санхүүжилтээр эхэлсэн “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчлийн мониторинг, хараат бус хэвлэл мэдээллийн эрхийг дэмжих нь” төслийн нэг хэсэг болох мониторингийн үр дүнд тулгуурласан юм. Манай байгууллага Улаанбаатар хот, 21 аймагт ажиллаж буй төлөөлөгчдөөр дамжуулан үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчилд мониторинг хийж байна. 2007 онд хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эрхийн зөрчлийн 37 тохиолдол бүртгэгджээ. Энэ бүлэгт бид мөн дээр дурдсан төслийн хүрээнд зохион байгуулсан сургалт, семинар, уулзалт зэрэг арга хэмжээнд оролцсон сэтгүүлч, хуульчдын санаа бодол, эрх баригчдаас хэвлэл мэдээллийн чиглэлээр хэлсэн үг, хэвлэл мэдээллээр өгсөн ярилцлага, Иргэний хууль, Эрүүгийн хуулийг хэрхэн ашиглаж буй, хэвлэл мэдээллийн өмчлөл, нууц эх сурвалжийн ашиглалтын судалгаа, мэдээлэл олж авах боломжийн судалгааны тоо баримтыг ашиглав.

Тайлангийн III бүлэгт ерөнхий дүгнэлт, цаашид хийвэл зохих зүйлийн тухай санал дэвшүүлсэн болно.

Та бүхэн Монголын хэвлэл мэдээллийн салбарт болсон анхны өлсгөлөнгийн үйл явцын товчооныг хавсралтаас үзэж болно.



Нэг. Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний баталгаа

Үндсэн Хууль

Монгол Улсын Үндсэн Хуулийн 16 дугаар зүйлд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг хамгаалж, дор дурдсан заалтаар баталгаажуулсан.

Монгол Улсын иргэн дараахь үндсэн эрх, эрх чөлөөг баталгаатай эдэлнэ:

16.16. Итгэл үнэмшилтэй байх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх, тайван жагсаал, цуглаан хийх эрх чөлөөтэй. Жагсаал, цуглаан хийх журмыг хуулиар тогтооно.

16.17. Төр, түүний байгууллагаас хууль ёсоор тусгайлан хамгаалбал зохих нууцад хамаарахгүй асуудлаар мэдээлэл хайх, хүлээн авах эрхтэй. Хүний эрх, нэр төр, алдар хүнд, улсыг батлан хамгаалах, үндэсний аюулгүй байдал, нийгмийн хэв журмыг хангах зорилгоор задруулж үл болох төр, байгууллага, хувь хүний нууцыг хуулиар тогтоон хамгаална.

Олон улсын эрх зүй

Монгол Улс НҮБ-ын гишүүний хувьд Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалыг хүлээн зөвшөөрсөн. 1974 онд Иргэний болон Улс Төрийн Эрхийн Олон Улсын Пактад нэгдэн орсон. Иймд Монгол Улс дээрх хоёр бичиг баримтын 19-р зүйлд заасан үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөг олон улсын эрх зүйн дагуу хамгаалах үүрэгтэй.

Үүнийгээ Монгол Улсын Үндсэн хуулийн 10 дугаар зүйлд албан ёсоор хүлээн зөвшөөрсөн:

1. Монгол Улс олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн хэм хэмжээ, зарчмыг баримталж, энхийг эрхэмлэсэн гадаад бодлого явуулна.
2. Монгол Улс олон улсын гэрээгээр хүлээсэн үүргээ шударгаар сахин биелүүлнэ.
3. Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.
4. Монгол Улс Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.

1.1 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө ба хэвлэл мэдээлэл

Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх чөлөөний баталгаа нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжин хэрэгжиж, хэвлэлийн эрх чөлөөг бодитой болгодог. “Эрх зүйт төрд хэвлэл мэдээлэл давамгайлах үүрэгтэй” тухай олон улсын олон бичиг баримтад заасан байдаг. Хэвлэлийн эрх чөлөө нь олон нийтэд өөрийн улс төрийн удирдагчдын үзэл санаа болон асуудалд хандах байр суурийг нээх хамгийн сайн арга хэрэгсэл болдог.

Европын Хүний эрхийн шүүх гэхэд “олон нийтийн сонирхлын бүх салбарт мэдээлэл түгээх нь хэвлэл мэдээллийн үүрэг” гэж заасан.

Хэвлэлийн эрх чөлөө нь “хөндлөнгийн нөлөөлөл, оролцооноос ангид чөлөөтэй байх явдал” (орч. Ц.Дашдондов) хэмээн Олон Улсын Сэтгүүлчдийн Холбоо (ОУСХ) тодорхойлсныг НҮБ, олон улсын хүний эрхийн байгууллага, улс орнуудын засгийн газар хүлээн зөвшөөрсөн байдаг.

ОУСХ-ны 21-р их хурлаас баталсан “Ардчилсан хэвлэл мэдээллийн хэрэгслийн соёлын тунхаг”-т “Ардчилсан нийгэмд мэдээллийн хэрэгслийн гүйцэтгэх үүрэг онцгой өвөрмөц агаад тухайлсан үүргийг ухаарч сэхээрсэн тэр цагт ардчилал бүрнээ үнэ хүндтэй болох учиртай” (орч. Ц.Дашдондов) гэсэн байдаг.

Хэвлэлийн эрх чөлөөний тухай хууль

1998 оны 8 дугаар сарын 28-ны өдөр УИХ-аас Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хууль баталсан юм.

Хуулийн 1 дүгээр зүйл:
Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүний үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх, үг хэлэх, хэвлэн нийтлэх эрх чөлөөг баталгаажуулахад оршино.
<i>Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиас</i>

Энэ хуулийн 2-р зүйлээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, хэвлэл мэдээллийн хэрэгслийн чөлөөт байдлыг хязгаарласан хууль батлан гаргахыг хориглосон юм.

Хуулийн 3 дугаар зүйлээр “төрөөс олон нийтийн мэдээллийн агуулгад хяналт /цензур/ тавихыг хориглож, Хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь өөрийн нийтэлж, нэвтрүүлж байгаа зүйлийнхээ төлөө хариуцлага хүлээнэ” гэж заасан ба 4-р зүйлээр “Төрийн байгууллага өөрийн мэдэлд хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байхыг хориглоно” гэжээ.

1998 оны 8-р сарын 28-ны “Хэвлэлийн эрх чөлөөний тухай хуулийг хэрэгжүүлэх тухай” УИХ-ын 103 тоот тогтоолоор төрийн мэдлийн өргөн нэвтрүүлгийг олон нийтийн болгон өөрчлөн байгуулахаар заасан билээ.

Зар сурталчилгааны тухай хууль

Монгол Улсад хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчийн үйл ажиллагааг зохицуулсан хууль байхгүй. Харин 2002 оны 5-р сарын 30-ны өдөр батлагдсан Зар сурталчилгааны тухай хуулийн 3-р бүлэгт “мэдээлэх хэрэгсэл” гэсэн тодорхойлолт байдаг ба үүнийг Улсын Дээд шүүх тайлбар гаргахдаа үндэс болгодог.

Зүйл 3.1
Энэ хуульд хэрэглэсэн дараахь нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно:
3.1.5 “Мэдээлэх хэрэгсэл” гэж телевиз, радио, холбооны шугам сүлжээ, компьютерийн сүлжээ, тусгай программ, хэвлэл болон бусад арга хэрэгсэл” гэсэн утгаар ойлгоно.
<i>Зар сурталчилгааны тухай хуулиас</i>

Олон нийтийн радио телевизийн тухай хууль

Монголд олон нийтийн радио, телевиз байгуулагдсан нь эрх баригчдаас сүүлийн жилүүдэд хэвлэлийн эрх чөлөөг бататгах чиглэлээр авч хэрэгжүүлсэн өндөр ач холбогдол бүхий чухал арга хэмжээ байлаа.

1998 оноос хойш долоон жил саатсаны эцэст Улсын Их Хурлаас 2005 оны 1 дүгээр сарын 17-ний өдөр Олон нийтийн радио, телевизийн (ОНРТ) тухай хууль батлан гаргав.

ОНРТ-ийн тухай хууль 2005 оны 7-р сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж эхэлсэн юм. Монголын Үндэсний Радио, Телевизийн Хэрэг эрхлэх газар татан буугдаж, оронд нь Монголын Үндэсний Олон Нийтийн Радио, Телевиз (МУОНРТ) байгуулагдан 2006 оны 2 дугаар сарын 8-ны өдөр Хууль Зүй, Дотоод Хэргийн Яамны Улсын нэгдсэн бүртгэлд бүртгүүлсэн байна.

Эрүүгийн хууль

2002 онд батлагдсан Эрүүгийн хуулийн 139-р зүйлд “сэтгүүлчийн хуульд нийцсэн үйл ажиллагаанд саад хийхийг гэмт хэрэг” гэж үзсэн шинэ заалт орсон.

139.1. Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд тараах, эсхүл тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг гучин нэгээс тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

139.2. Энэ хэргийг албан тушаалын байдлаа ашиглаж үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуу дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш, зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулиас

Эрүүгийн хуулийн энэ заалтыг ашиглан, сэтгүүлчдийн эсрэг хэд хэдэн зөрчлийг шийдвэрлүүлэхээр нэхэмжлэл гаргасан боловч өнөө хэр амжилт олсон тохиолдол алга байна. “Хүний эрхийг хангах үндэсний хөтөлбөр”-ийн 2006–2008 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд Дээд Шүүх, “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага хамтран Эрүүгийн хуулийн энэ зүйлд Дээд шүүхийн тайлбар гаргахаар тусгасан юм. Гэтэл Монгол улсын Дээд шүүх тус байгууллагатай зөвлөлдөлдгүйгээр 2007 оны 12-р сарын 21-ний өдөр тайлбар гаргасан байна.

Тайлбарыг <http://www.globeinter.org.mn/?cmd=Record&menuid=4> вэб сайтаас бүрэн эхээр нь авч болно.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын хуульчийн хийсэн дүгнэлтээр бол энэ тайлбар зарим талаар шаардлагад нийцэхгүй байна.

- Уг тайлбар нь Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлийг хэрхэн ойлгож нэг мөр хэрэглэх явдлыг хангахуйц хэмжээний тайлбар болж чадаагүй. Өөрөөр хэлбэл, ердөө л зарим нэг үгийг хэрхэн ойлгох вэ гэдгийг л тайлбарласан нэр томъёоны тайлбар болжээ гэсэн дүгнэлтэд хүргэж байна.
- Улсын Дээд Шүүхээс Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан гэмт хэргүүдийн талаар тайлбар гаргахдаа эрүүгийн эрх зүйн судлал талаас нь буюу гэмт хэргийн бүрэлдхүүний элементүүдийг нь нэгбүрчлэн тайлбарлаж өгч байвал цаашид маш бодитой сайн тайлбар болох талтай байж болох юм. Гэмт хэргийн бүрэлдхүүн гэдэгт тухайн 139 дүгээр зүйлд заасан гэмт хэргийн улмаас хууль ёсны эрх, ашиг сонирхол нь хохирсон нийгмийн харилцаа, гэм буруугийн хэлбэр буюу үйлдэлдээ санаатай болон болгоомжгүй хандсаны аль нь болох, гэмт хэрэгт ял шийтгэгдэх учиртай болох, үйлдэл, эс үйлдэхүйн алинаар нь уг гэмт хэргийг үйлдэж болох тухай зэргийг тайлбарласан бол маш сайн болох байлаа.
- Энэхүү тайлбарт логикийн алдаатай зүйлүүд хэд хэд байна. Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд “Өөрийн болон бусдын ашиг сонирхлыг хөндсөн аливаа мэдээллийг нийтэд тараах болон тараалгахгүй байхын тулд сэтгүүлчийн хуульд нийцсэн мэргэжлийн үйл ажиллагаанд саад хийсэн бол...” гэж томъёолсон байдаг. Эндээс харахад уг гэмт хэрэг

нь гэм буруугийн санаатай хэлбэрээр үйлдэгддэг. Гэтэл тайлбарын 1.3-т "...үндэслэл бүхий шалтгаангүйгээр хүндрэл учруулсан аливаа үйлдэл, эс үйлдэхгүйг ойлгоно..." гэсэн байна. Санаатай гэмт хэрэгт "...шалтгаангүй..." буюу зорилгогүйгээр гэмт хэрэг үйлдэнэ гэсэн ойлголт байх боломжгүй мэт санагдана.

- Тогтоолын 1.4, 1.5-д "...нийтэд тараах...", "...тараалгахгүй байх..." гэсэн үгийн утгыг тайлбарлажээ. Гэтэл эдгээр үг нь хуулийн томъёололд орж илэрхийлж байгаа утга санаа нь юу гэсэн үг болох тухай тайлбарлаагүй байна. Эрүүгийн хуулийн 139 дүгээр зүйлд "...нийтэд тараах..." гэдэг үг нь сэтгүүлчийн өөрөө тараахыг хүсээгүй үнэн бодит байдалд нийцээгүй мэдээллийг хэн нэгэн этгээд нийтэд тараах зорилгоор сэтгүүлчийг албадсан байхыг гэмт хэрэг гэж үзэх тухай заасан. Гэтэл энэ тухай Улсын Дээд Шүүхийн тайлбарт юу ч дурдаагүй байна.

1.2 Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний хязгаарлалт

Төрийн нууц

Монгол Улсад төрийн нууцыг Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар хамгаалдаг. Төрийн нууцын тухай хууль 1995 онд батлагдаж, хамгийн сүүлд 2004 оны 1-р сарын 2-нд нэмэлт өөрчлөлт оруулсан. Төрийн нууцын тухай хуульд: "Төрийн нууц" гэж Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу төрийн нууцад хамааруулсан, тус улсын гадаад бодлого, эдийн засаг, шинжлэх ухаан, техник-технологи, батлан хамгаалах, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажилтай холбоотой бөгөөд задруулбал үндэсний аюулгүй байдалд хор хохирол учруулахуйц мэдээллийг томъёолол, дүрс зураг, дохио тэмдэг, техник – технологийн шийдэл болон үйл ажиллагааны хэлбэрээр өөртөө агуулж байгаа мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг хэлнэ" гэж тодорхойлсон байдаг.

Хуулийн 11-р зүйлд зааснаар "Төрийн нууцыг задруулснаас Монгол Улсын ашиг сонирхол, аюулгүй байдалд учирч болох хор уршгийн хэмжээнээс хамааран төрийн нууцын зэрэглэлийг тогтооно" гэсэн бөгөөд төрийн нууц нь онц чухал-маш нууц, маш нууц, нууц гэсэн гурван зэрэглэлтэй байна.

Төрийн нууцын тухай хуулиар төрийн нууцыг үндсэн 5 төрөлд ангилдаг.

Мөн Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулиар 59 зүйлийн мэдээллийг, тухайлбал үндэсний аюулгүй байдлын хүрээнд 19, батлан хамгаалах хүрээнд 14, эдийн засаг, шинжлэх ухаан, техник, технологийн хүрээнд 5, тагнуул, сөрөх тагнуул, гүйцэтгэх ажлын хүрээнд 15, бусад хүрээнд 6 зүйлийн мэдээллийг нууцлахаар тогтоожээ. Нийт 59 зүйлээр тогтоосон мэдээллийн 69.5 хувийг 40–60 жилээр, эсвэл байнга нууцалсан байна.

Нууцалсан зэрэглэлээр үзвэл онц чухал-маш нууц мэдээлэл 6, маш нууц мэдээлэл 24, нууц мэдээлэл 7 байна. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулинд шууд зааж өгөөгүй, нууцалсан зэрэглэлээр гэж ангилсан 25 мэдээлэл байгаа юм.

2004 оны 4-р сарын 23-нд нэмэлт оруулсан Төрийн нууцын жагсаалтын хуульд "Терроризмтой тэмцэх ажиллагаатай холбогдох мэдээ, баримт бичгийг бүхэлд нь нууцалсан зэрэглэлээр, байнга"-ын хугацаагаар нууцлах ажээ.

Эрүүгийн хуулийн 87.1 дүгээр зүйлд төрийн нууц задруулах гэмт хэргийг зааж өгсөн байдаг. Үүнд "Төрийн нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагааг итгэмжлэгдэн хариуцсан буюу албан тушаал, ажил үүргийн хувьд мэдсэн этгээд задруулсан нь эх орноосоо урвах, тагнуул хийх гэмт хэргийн шинжгүй бол таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ", 87.2 дугаар зүйлд "Энэ хэргийн улмаас хүнд хор уршиг учирсан бол таваас дээш найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ" гэж заасан байдаг.

2007 онд “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас Төрийн нууцын тухай хуулийг өөрчлөн шинэчлэх зорилгоор хуулийн харьцуулсан судалгаа, төрийн байгууллагаас мэдээлэл олж авах өдөөх судалгаа хийж, хуулийн шинэ төсөл боловсруулан Тагнуулын ерөнхий газар, Хууль зүй, дотоод хэргийн яаманд санал болгосон.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын санал, уриалгыг Тагнуулын ерөнхий газар нааштай хүлээн авч, Төрийн нууцын тухай хууль, Төрийн нууцын жагсаалтын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Мөн УИХ-ын ажлын хэсэг байгуулагдсан билээ.

Байгууллагын нууц

1995 оны 5 дугаар сарын 16-ны өдөр баталсан Байгууллагын нууцын тухай хуулиар байгууллагын нууц нь тухайн байгууллагын хамгаалалтад байна. Байгууллага нь нууцаа хамгаалах журмыг өөрөө тогтоож мөрдөнө гэж заасан /5.1/. Энэ хатуу заалтыг 6 дугаар зүйлээр зөөлрүүлэх оролдлого хийж нууцлахыг хориглох мэдээллийн жагсаалтыг баталсан. Үүнд тухайн байгууллагын явуулж буй үйл ажиллагаа, үйлдвэрлэл, үйлчилгээ, ашиглаж буй техник, технологийн хүн амын эрүүл мэнд, хүрээлэн буй орчинд үзүүлэх буюу үзүүлж байгаа нөлөөллийг илтгэн харуулах мэдээлэл бол, мөн тухайн байгууллагын мэдэлд байгаа бөгөөд хадгалалт, хамгаалалтын горим нь зөрчигдсөн тохиолдолд хүн амын эрүүл мэнд, хүрээлэн байгаа орчинд аюул учруулж болзошгүй бүх төрлийн хорт, цацраг идэвхт бодисын хор хөнөөлийг тодорхойлсон мэдээллийг нууцлахыг хоригложээ. Мөн гэмт хэргийн тухай болон нийгэд мэдээлэхээр хуульд заасан бусад мэдээллийг байгууллага нууцалж болохгүй ажээ.

Эрүүгийн хуулийн 164-р зүйлээр санхүүгийн болон аж ахуйн үйл ажиллагааны нууцыг хууль бусаар олж авах, задруулбал торгохоос эхлэн гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэхээр заасан. Энэ хэргийн улмаас их хэмжээний хохирол учирсан бол дээд тал нь гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэх юм байна.

Гүтгэлэг, доромжлол, нэр төр, алдар нэр, нэр хүндтэй холбоотой хууль тогтоомж

Үндсэн хуулийн 16.17-д мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг бусдын “нэр төр, алдар хүндийг хамгаалах” үүднээс хязгаарлаж болно гэж заасан.

2002 оны 9 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр үйлчилж буй Эрүүгийн хуулийн 110, 111-р зүйлээр нэр төр, алдар хүндийг доромжилсон гүтгэлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр тараасан бол гэмт хэрэг гэж үзсэн байдаг.

110 дугаар зүйл. Доромжлох

110.1. Бусдын нэр төр, алдар хүндийг олон нийтийн өмнө, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Эрүүгийн хуулиас

111 дүгээр зүйл. Гүтгэх

111.1. Хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүжирдлэг тараасан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

111.2. Гүтгэлгийг хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд тараасан, эсхүл доромжлох, гүтгэх гэмт хэрэгт урьд ял шийтгүүлсэн этгээд үйлдсэн бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг тавин нэгээс нэг зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурваас дээш зургаан сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

111.3 Хүнд, онц хүнд гэмт хэрэгт холбогдуулан яллуулахаар гүтгэснээс хүнд хор уршиг учирсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг нэг зуун тавин нэгээс хоёр зуун тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ

Эрүүгийн хуулиас

Эрүүгийн эдгээр зүйлд Улсын Дээд шүүхээс 2007 оны 10-р сарын 29-нд гаргасан тайлбарт дээрх зүйлд дурдагдсан нэр төр, алдар хүнд, доромжлох, гутаах зорилго, худал гүжирдлэг, олон нийт, урьд ял шийтгүүлсэн гэх мэт нэр томъёог тайлбарлажээ.

Дээд шүүхийн тайлбараар бол:

“... нэр төр...” гэж тухайн хүний хувийн болон ёс зүй, түүнчлэн ажил хэргийн чадвар, мэргэжлийн түвшингийн талаар бусдаас өгч буй үнэлэмжийг хэлнэ.

“...алдар хүнд ...” гэдэгт бусдаас өөрийнх нь талаар өгсөн үнэлгээнд тулгуурлан өөртөө өгсөн тухайн хүний үнэлэмжийг ойлгоно.

“...доромжлох...” гэдэгт нийгэмд тогтсон хүмүүсийн хоорондын харилцааны болон ёс суртахууны шаардлагын хэм хэмжээ, үндэсний зан заншил, уламжлалд харшилсан, тухайн хүний нэр төр, алдар хүндийг санаатай гутаасан үйлдлийг хэлнэ. Энэ нь хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, эрүүл мэнд, шашин шүтлэг, үзэл бодол, боловсрол, гадна төрх, хөгжлийн бэрхшээлтэй болон гэр бүлийн байдалтай нь холбогдуулан үг, үйлдэл, бичгээр, дохио зангаагаар, зураг дүрсээр гутаасан зэргээр илэрнэ. Тайлбарын 1.6-д “Доромжлох нь хэлбэрийн бүрэлдхүүнтэй гэмт хэрэг тул үйлдэл хийснээр төгссөн гэмт хэрэгт тооцогдоно” гэжээ. Тайлбарын 3.1-д “Хүний хувийн нууцыг задруулах замаар доромжилсон бол нийлмэл гэмт хэрэг гэж үзэж, Эрүүгийн хуулийн 110, 136 дугаар зүйлээр давхар зүйлчилнэ” гэсэн байна.

Тайлбарыг <http://www.globeinter.org.mn/?cmd=Record&menuid=4> вэб сайтаас бүрэн эхээр нь авч болно.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага энэ тайлбарыг дэвшилттэй гэж үзэхгүй байгаа бөгөөд манай хуульч нэр төр, алдар хүнд гэсэн ойлголтыг олон улсын жишигт тохирохгүй, гүтгэх, доромжлох хэргүүдийг хэлбэрийн бүрэлдхүүнтэй хэрэг гэдэг нь тийм ч зөв тайлбар биш, ялангуяа “гүтгэх гэмт хэрэг дээр хэлбэрийн бүрэлдхүүнтэй гэж тайлбарласан нь гүтгэсэн гэж үзэж байгаа мэдээлэл үнэн бодит байдалд нийцэхгүй, худлаа мэдээлэл юм гэдэг нь тогтоогдвол шууд л гэмт хэрэг үйлдсэн байна гэж ойлгохоор болсон байна” гэсэн дүгнэлт хийсэн юм.

2002 оны Иргэний хуулийн 21 дүгээр зүйлээр иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг хамгаалсан байна.

21.2. Иргэний нэр, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүндийг гутаасан мэдээ тараасан этгээд түүнийхээ үнэн зөвийг нотолж чадахгүй бол эрх нь зөрчигдсөн этгээдийн шаардлагаар уг мэдээг тараасан хэлбэр, хэрэгсэл, эсхүл өөр хэлбэр, хэрэгслээр няцаах үүрэг хүлээнэ.

Иргэний хуулиас

Иргэний хуулийн 497–р зүйлийн нэг дэх хэсэгт “Бусдын эрх, амь нас, эрүүл мэнд, нэр төр, алдар хүнд, ажил хэргийн нэр хүнд, эд хөрөнгөд хууль бусаар санаатай буюу болгоомжгүй үйлдэл /эс үйлдэл/–ээр гэм хор учруулсан этгээд уг гэм хорыг хариуцан арилгах үүрэгтэй” гэж заажээ.

Мөн “Иргэний дүрсийг гэрэл зураг, кино, дүрс бичлэгийн хальс, хөрөг зураг болон бусад хэлбэрээр өөрийнх нь зөвшөөрөлгүйгээр нийтэлсэн, олон нийтэд үзүүлсэн тохиолдолд (21.5) тухайн этгээд гэм хорыг арилгуулахыг шаардах эрхтэй.

Монголд улс төрч, төрийн өндөр албан тушаалтан, албан хаагчдын шүүмжлэлд хүлээцтэй хандах талаар гаргасан эрх зүйн акт байхгүй. Харин энэ Эрүүгийн хууль батлагдахаас өмнө 1994 оны Иргэний хуулийн 7, 392 дугаар зүйлийг хэрэглэх тухай Улсын Дээд Шүүхийн зөвлөмж 2000 онд гарсан байдаг. Зөвлөмжийн 13–т “төр, засгийн байгууллага, тэдгээрийн албан тушаалтан нарын албаны үйл ажиллагаа, үзэл баримтлал, авч буй арга хэмжээг олон түмний зүгээс шүүмжилж байгаа явдал байгууллага, ажилтны нэр төрийг гутааж буй явдал биш болно. Гэхдээ хэм хэмжээнээс хэтэрсэн шүүмжлэл нь бусдын нэр төрийг гутаахад чиглэгдсэн буюу ийм байдалд хүргэсэн бол нэр төр гутаагдсан гэж үзнэ” хэмээжээ.

Энэ зөвлөмж өнөө хэр хүчинтэй эсэх, 2002 оны Иргэний хуульд үйлчлэх эсэх талаар Дээд шүүхээс ямар нэг мэдээлэл гараагүй байна.

Бусад хязгаарлалт

Монголд үзэл бодлоо илэрхийлэх ба мэдээллийн эрх чөлөөг хязгаарласан бусад олон тооны хууль тогтоомж байдаг. 2001 онд “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага, Лондон хотод төвтэй олон улсын 19–р зүйл (ARTICLE 19) байгууллагатай хамтран монголын 232 хуульд хийсэн судалгаагаар ийм хууль, хуулийн заалт 91 байсан.

Эрүүгийн хуулиар сэтгүүлчдийг шийтгэж болзошгүй зарим заалтыг энд дурдав.

Эрүүгийн хуулийн 136.1–д зааснаар “Хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцыг албаны болон мэргэжлийн үйл ажиллагааг хэрэгжүүлэх явцдаа мэдсэн этгээд задруулсан бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг хориос тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ”.

Мөн хуулиар садар самууныг сурталчилсан (123–р зүйл), иргэний захидал харилцааны нууцын халдашгүй байдлыг зөрчсөн (135–р зүйл), шашны харгис үзэл номлолыг санаатай сурталчилсан буюу тараасан бол (144.1–р зүйл), Хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, прокурор, шүүгчийн зөвшөөрөлгүйгээр эрүүгийн хэргийн мэдээ баримтыг задруулсан бол (257.1–р зүйл) торгохоос нэгээс гурван сарын хугацаагаар баривчлах хүртэл ял шийтгэх ажээ.

Мөн олон нийтийн дунд дайн явуулахыг сурталчилсан, дайнд уриалсан бол (298.1–р зүйл) нэгээс гурван сар баривчлах ба энэ хэргийг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл ашиглах замаар буюу төрийн албан хаагч үйлдсэн бол хоёроос таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

231 дүгээр зүйл. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг доромжлох

231.1. Төрийн албан хаагч, хэв журам хамгаалах олон нийтийн байцаагчийг үүргээ гүйцэтгэж байгаатай нь холбогдуулан олны өмнө доромжилсон бол хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг таваас тавь дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, нэг зуугаас нэг зуун тавин цаг хүртэл хүртэл хугацаагаар албадан ажил хийлгэх, эсхүл нэгээс гурван сар хүртэл хугацаагаар баривчлах ял шийтгэнэ.

Иргэний хуулиас

Энэ хуульд тайлбарласнаар “Төрийн албан хаагч” гэдэгт шүүгч, прокурор, хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, гааль, татварын албаны байцаагч, хууль тогтоомжоор тусгайлан эрх олгосон улсын байцаагч нарыг хамруулан ойлгоно.

1.3 Мэдээллийн эрх чөлөө

Монгол Улсад төрийн, байгууллагын, хувийн нууцыг хуулиар хамгаалсан атлаа төрийн байгууллагаас мэдээлэл авах тухай хууль тогтоомж байхгүй.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас 2002 онд Монголын Нээлттэй Нийгэм Хүрээлэн (одоогийн ННФ), АНУ-ын Элчин Сайдын Яам, Австралийн Олон улсын Хөгжлийн Агентлагийн санхүүгийн дэмжлэгээр мэдээллийн эрх чөлөөний мөн чанар, үзэл баримтлал, зарчмуудыг түгээн дэлгэрүүлэх, ойлгуулах чиглэлээр өргөн хүрээтэй үйл ажиллагаа явуулж, 2004 онд Мэдээллийн эрх чөлөөний тухай хуулийн анхны төслийг Хууль зүй, дотоод хэргийн яаманд танилцуулсан юм. Энэ хуулийг хэлэлцэж батлахаар УИХ-аас 2005 оны 11-р сард чуулганы хэлэлцэх асуудлын дэгд оруулсан байв. Гэвч энэ хууль өнөө хэр батлагдаагүй байна.

2006 оны 10 дугаар сард Засгийн газрын хуралдаанаар энэ хуулийг УИХ-д өргөн барих асуудлыг хэлэлцсэн боловч мэдээлэл түгээх, мэдээллийн аюулгүй байдлын зохицуулалттай уялдуулан багцлан хэлэлцэхээр болж хойшлуулсан байна.

2007 оны 5 дугаар сарын 2-нд Дэлхийн хэвлэлийн эрх чөлөөний өдрийг тохиолдуулан УИХ-ын нэр бүхий дөрвөн гишүүн “Мэдээлэл олж авах эрх, эрх чөлөөний тухай хууль”-ийн төсөл боловсруулж, УИХ-д өргөн барьсан боловч өнөө хэр хэлэлцэгдээгүй байна.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын хийсэн судалгаагаар 2007 онд хүчин төгөлдөр үйлчилж буй 120 орчим хуульд мэдээлэл нээлттэй байх заалт орсон байна.

1.4 Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах нь

Сэтгүүлчийн мэдээллийн эх сурвалжаа хамгаалах асуудал нь ардчилсан нийгэмд олон нийтийн “хоточ нохой” байх чухал үүргээ биелүүлэхэд нь хэвлэл мэдээлэлд боломж олгох үндсэн арга юм. Монгол Улсад сэтгүүлчийн мэдээллийн нууц эрх сурвалжийг хамгаалах хууль тогтоомж байхгүй. МСНЭ-ийн баталсан “Монголын сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчим”-аар үүнийг хүлээн зөвшөөрсөн боловч амьдралд хэрэгждэггүй.

Дөрөв. Хүний итгэлийг хүлээж олсон мэдээллийнхээ эх сурвалжийг ямар ч тохиолдолд чанад нууцална.

Монголын сэтгүүлчдийн баримтлах ёс зүйн зарчим

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага Сэтгүүлчийн нууц эх сурвалжийг хамгаалах хуулийн төсөл боловсруулах ажлыг 2007 оны 10-р сард эхлээд байна.

1.5 Хэвлэл мэдээллийн өмчлөл

Монгол Улсад хэвлэл мэдээллийн өмчлөл, түүний ил тод байдлыг хангах, хэвлэл мэдээллийн төвлөрлийн эрх зүйн зохицуулалт байхгүй. Мөн өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн үйл ажиллагааг зохицуулсан хууль байхгүй.

1998 оны Хэвлэл мэдээллийн эрх чөлөөний тухай хуулиар төр ХМХ өмчлөх эрхийг хориглосноор төрийн мэдлийн сонин хэвлэлийг хувьчилж, өргөн нэвтрүүлэг нь олон нийтийн болох шилжилтийн үед явж байна. Тус хуулийг хэрэгжүүлэх УИХ-ын тогтоолоор монголын цорын ганц мэдээллийн агентлаг болох МОНЦАМЭ нь олон нийтийн болох ёстой боловч өнөө хэр төрийн мэдэлд байгаа бөгөөд англи хэл дээрх “Монгол мессенжер”, орос хэл дээрх “Новости Монголии”, хятад хэл дээрх “Монгу Сяосибao”, долоо хоног дутмын япон хэл дээрх “Монгору Цушин”, “МОНЦАМЭ мэдээ” өдөр дутмын мэдээллийн товхимол, хуучин монгол бичиг дээрх “Хүмүүн бичиг” долоо хоног дутмын зэрэг 10 сонин хэвлэл эрхлэн гаргадаг.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслүүд Иргэний хууль, Компаний тухай хууль зэрэг хуулиар үйл ажиллагаагаа зохицуулдаг.

5.1. Монгол Улс дэлхийн эдийн засгийн хөгжлийн түгээмэл хандлага, өөрийн орны өвөрмөц онцлогт нийцсэн олон хэвшил бүхий эдийн засагтай байна

5.2. Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална

Монгол Улсын Үндсэн Хуулиас

Өмчийн төрөл хэлбэрийн талаар Иргэний хуулийн 99 дүгээр зүйлд зааснаар “Монгол Улсад нийтийн болон хувийн өмч” –ийг баталгаажуулсан. Нийтийн өмч нь төрийн, орон нутгийн, шашны, олон нийтийн гэсэн хэлбэртэй байна (99.2). Нийтийн болон хувийн өмч нь холимог хэлбэрээр байж болно (99.4) Мөн Иргэний хуулийн 25 дугаар зүйлд зааснаар хуулийн этгээд нь ашгийн төлөө, ашгийн төлөө бус байж болохыг заажээ.

ХМХ-ийн өмчийн хэлбэрийг тодорхой заасан цорын ганц хууль нь Олон нийтийн радио, телевизийн тухай хууль юм. Энэ хуулийн 16 дугаар зүйлд зааснаар МҮОНРТ-ийн өмч нь олон нийтийн өмч юм. Иргэний хуулиас харахад хуулийн этгээд нь зөвхөн нөхөрлөл, компани, холбоо, сан, хоршоо гэсэн төрөлтэй байх ёстой. Гэхдээ энэ заалт нь зарим талаараа Олон нийтийн радио, телевизийн тухай хуультай зөрчилддөг. Тодруулбал, Монголын Үндэсний олон нийтийн радио, телевиз нь Иргэний хуулийн 33 дугаар зүйлд заасан нөхөрлөл, компани, холбоо, сан, хоршоо гэсэн хуулийн этгээдийн төрлүүдийн алинд ч хамаарахгүй байгаа нь харагдаж байна. Энэ нь Иргэний хуулийн энэ зохицуулалт нь цаг үеэсээ хоцрогдсон, зайлшгүй шинэчлэн орчин үеийн нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн өөрчлөх ёстой болсон нь харагдаж байна.

Үүнээс гадна Төрийн бус байгууллагын тухай хууль 1997 оноос үйлчилж буй, цөөнгүй ХМХ төрийн бус байгууллагын статустай үйл ажиллагаагаа явуулдаг. Тэдгээр нь Хууль зүй, дотоод хэргийн яаманд бүртгэлтэй. Төрийн бус байгууллага нь нийгэмд үйлчилдэг, гишүүддээ үйлчилдэг гэсэн хоёр хэлбэртэй байна.

4 дүгээр зүйл: “Төрийн бус байгууллага” гэж иргэд төрийн байгууллага /хууль тогтоох, гүйцэтгэх, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэх байгууллагаас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллагыг” хэлнэ

Төрийн бус байгууллагын тухай хуулиас



Хоёр. Хараат бус хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдийн эрхийн зөрчил

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас 2005 оны 10-р сараас эхлэн Нээлттэй Нийгэм Форум, ННХ-ийн Хэвлэл мэдээллийн бүсийн санхүүжилтээр үзэл бодлоо илэрхийлэх зөрчлийн мониторинг хийж эхэлсэн юм. Үүнээс хойш үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зөрчлийн 80 шахам баримт мэдээ бүртгэгдсэн байна. Үүний 37 нь энэ тайлангийн хугацаанд гарчээ. Үүнийг зөрчлийн хэлбэрээр ангилбал:

✦ Эрүүл мэндэд халдсан	3
✦ Мэдээлэл хайх, олж авах, түгээх	20
✦ Хэвлэн нийтэлсний төлөө эрүүгийн гэмт хэрэгт буруутгасан	2
✦ Хоригдсон	2
✦ Шүүхийн, бусад төрлийн дарамт	9
✦ Бусад	1

Манай оронд сэтгүүлчийн мэргэжлийн үйл ажиллагаанд саад учруулахыг “гэмт хэрэг” гэж үзсэн, цагдан хяналт /цензур/-ыг хориглосон хууль тогтоомж байдаг ч амьдрал дээр огт хэрэгжихгүй байгаа юм.

Мэргэжлийн ажил үүргээ гүйцэтгэж яваа сэтгүүлчид элдэв төрлийн дайралтад өртөх, мэдээлэл олж авах явцдаа янз бүрийн саад бэрхшээлтэй учрах, тэднийг эх сурвалжаа илчлэхийг шаардах, мэдээлэл өгөхөөс татгалзах, тэр бүү хэл биеийн эрх чөлөөнд нь халдаж эрүүл мэндийг нь хохироох зэрэг зөрчил илэрч байгаа нь Монголын сэтгүүлчдийн ажиллах нөхцөл амаргүй түвэгтэй байгааг илтгэж байна.

Өөрсдийнх нь эсрэг шинэ дайралт ихсэхээс болгоомжлон тухайн тохиолдлыг олон нийтэд мэдээлэхийг хүсээгүй, эсвэл нэрийг нь дурдахаас татгалзсан сэтгүүлч цөөнгүй байгаа тул бид бүх зөрчлийн жишээ баримтыг энэ тайланд өгүүлж чадаагүй билээ.



Өнөөдөр Монголд хэвлэлийн эрх чөлөө байна гэж би хэлж чадахгүй. Сэтгүүлчид, редакциуд эдийн засгийн ямар ч эрх чөлөөгүй нөхцөлд ажиллаж байхад хэвлэлийн эрх чөлөө гэж байхгүй. Бараг бүх хэвлэл хэн нэгэн нөлөө бүхий, мөнгөтэй хүнээс ямар нэг байдлаар хараат ажиллаж байна. Хэвлэлийн эрх чөлөө гэдэг бол хэвлэгдэн гарч байгаа сонин хэвлэлийн тоо огт биш. Сэтгүүлчид өөрсдөө айдас хүйдэс, ядуурал, авлигын дунд ажиллаж байгаа бол тэнд хэвлэлийн эрх чөлөө байхгүй гэсэн үнэн үгийг би давтан давтан хэлмээр байна. Сэтгүүлчид өөрсдийнхөө төлөө тэмцэж чадахгүй байгаа бол бусдын төлөө тэмцэж чадахгүй.

“Улстөрийн сонин”-ы эрхлэгч Г.Уянга

2.1 Сэтгүүлчийн хувийн аюулгүй байдал

Монголд сэтгүүлчдийн биеийн эрх чөлөөнд халдаж, эрүүл мэндийг хохироох явдал гарч байгаа нь сэтгэл түгшүүлж байна. Мөн эрүүл мэнд нь ноцтойгоор хохироогүй л бол манай сэтгүүлчид тухайн халдлагыг ойшоон үздэггүй байна. Мөн дийлэнх сэтгүүлч халдлагын талаар мэдээлбэл дараа нь улам их заналхийлэлд өртөнө гэсэн болгоомжлолтой байдаг аж.

Орхон аймгийн “Шинэ мэдээ” сонины редактор Д.Цэнд-Аюушийг 2007 оны 3-р сарын 22-ны орой 23 цагийн үед гэртээ орох гэж явахад нь 4-5 залуу бүлэглэн зодож энгэрийн дотор халаасанд байсан түрийвчтэй мөнгө, үнэтэй гар утсыг аваагүй хэрнээ бичиг баримтыг нь авчээ. “Тэдгээр залуус нэгнийгээ Хишгээ гэж дуудаж байсан. Энэ халдлага ажил мэргэжилтэй маань холбоотой эсэхийг сайн мэдэхгүй. Гэхдээ үнэтэй гар утас байсаар байтал яагаад зөвхөн түрийвчтэй бичиг баримт авсан юм бол?” хэмээн тэр хэлсэн юм. Сэтгүүлч Д. Цэнд-Аюуш ингэж зодуулсны дараа ажилдаа очиж чадаагүй бөгөөд цагдаад хандаагүй ажээ.

2007 оны 06-р сарын 24-ний өдөр Сүхбаатар дүүрэгт байрлах “Чингис 3” ресторан шавьжтай хоол зарж байна гэсэн иргэдийн мэдээллийн дагуу “Нийгмийн толь” сонины фото сурвалжлагч С.Туул тус ресторанд очжээ. Тэрээр тус рестораны галын өрөөнд орж бохир орчинд хоол хийн иргэдэд үйлчилдэг болохыг нь нотлох фото зургууд, мөн үйлчлүүлэгчийн шавьжтай гэх тавагтай хоолны зургийг авсан байна. Түүнийг зургаа аваад гарах гэхэд тус рестораны менежер “Байгууллагын дотоод нууцад нэвтэрлээ, хувийн ресторанд зөвшөөрөлгүй зураг авлаа” хэмээн буруутгаж аппаратыг нь эвдэн, толгой руу нь цохижээ. Халдлагын улмаас толгой нь үе үе өвддөг болсон тухай фото сурвалжлагч С.Туул “Глоб Интернэшнл” ТББ-ын сүлжээний зохицуулагчтай уулзахдаа хэлжээ. Фото сурвалжлагч С.Туул энэ талаар 2007 оны 6-р сарын 25-нд Сүхбаатар дүүргийнхээ цагдаад өргөдөл гаргахаар очсон боловч цайны цаг гэсэн шалтгаанаар хүлээж аваагүй. 2007 оны 6-р сарын 26 буюу Мягмар гаригийн 17 цагт дахин очиход ажлын цаг дууссан маргааш ир гэж дахин буцаажээ. Маргааш нь буюу 2007 оны 6-р сарын 27-нд байцаагч Н.Ганхүү “Сэтгүүлч та нар хаана юу хийхээ мэддэггүй, яах гэж тэгж дураараа зураг хөрөг авдаг юм?” хэмээн загнаж өргөдлийг нь буцаажээ. “Нийгмийн толь” сонин дээр гарсан мэдээлэл, мөн иргэдийн гомдлын дагуу Нийслэлийн Мэргэжлийн Хяналтын газрын байцаагч Н.Валя “Чингис 3” рестораны үйл ажиллагааг шалгаж “эрүүл ахуйн шаардлага хангаагүй, хоолны чанар муу, мэргэжлийн тогооч ажиллаагүй” гэсэн дүгнэлт гарган үйл ажиллагааг нь түр хугацаагаар зогсоосон байна.

2.2 Сэтгүүлчдийн эсрэг дайралт

Сэтгүүлчдийн мэргэжлийн үйл ажиллагаанд хөндлөнгөөс оролцох, нөлөөлөх оролдлого хийх, элдэв шахалт дарамт үзүүлэх, сүрдүүлэх, мэдээлэл олж авах, түгээхэд саад тотгор болох зэрэг үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний зөрчил тохиолдсоор байна. Энэ нь манай улсад бүх төрлийн цагдан хяналт (цензур) бодитой байгаагийн илрэл юм.

Сэтгүүлчдийн эсрэг дайралт нь сүрдүүлэх, заналхийлэх, үг хэлээр дайран доромжлох, эд хөрөнгөнд нь халдах, баривчлах, саатуулан хорих зэрэг хэлбэрээр илэрч байна. Мөн сэтгүүлчийн нийтлэл, мэдээ баримтыг няцаан янз бүрийн мэдэгдэл гаргаж олон нийтийг төөрөгдүүлэх нь Монголын эрх баригчдын түгээмэл арга болсон байна.

Хувийн хэвшлийнхэн, иргэд ч сэтгүүлчдийн эсрэг дайран довтолж мэдээлэл цуглуулах, үйл явдлыг сурвалжлахад саад хийж байна. Мөн шүүх, цагдаа хүчний байгууллагууд сэтгүүлчдийг дарамтлах явдал ихэсч байгаа нь хараат бус хэвлэл мэдээлэл хөгжихөд ихээхэн саад болж байгаа юм.

Монгол Улсын Үндсэн Хууль, олон улсын гэрээ, хэлэлцээрийн заалтыг хэлбэрэлтгүй биелүүлэх нь төрийг төлөөлж буй албан тушаалтан, албан хаагч, эрх мэдэлтний иргэдийнхээ өмнө хүлээсэн үүрэг юм.

Хуулиа дээдлэн хүндэтгэж, сэтгүүлчдийн мэдээлэл цуглуулах, боловсруулах, олон нийтэд мэдээлэл түгээх үндсэн үүрэгт саад болсон гэм буруутай этгээдүүдэд хариуцлага хүлээлгэхийг “Глоб Интернэшнл” ТББ удаа дараа шаардан тухай бүрт хэвлэлийн мэдэгдэл гаргаж, албан захидал явуулсан ч төдийлөн ахиц гарахгүй байна. Зарим жишээг дор дурдав.

Баян-Өлгий аймгийн Тагнуулын албаны дарга Х.Энхсайхан 2007 оны 1-р сарын 18-ны өдөр МҮОНРТ-ийн орон нутаг дахь салбар Олон нийтийн радиогоор талийгаачийн эмгэнэлийг монгол хэлээр, өөрийн ажилтнаар уншуулах шаардлага тавьсан байна. Радиогийнхан казах хэлээр, эсвэл өөрийн нэвтрүүлэгчээр монгол хэл дээр уншуулах хүсэлт тавьжээ. Үүнтэй холбогдуулан Тагнуулын албаны дарга 2007 оны 1-р сарын 23-ны өдөр радиогийн захирлыг өрөөндөө дуудаж, “Шоронд хорино” хэмээн айлган сүрдүүлсэн байна. Ингэхдээ “Казах хэл дээр нэвтрүүлэг явуулах зөвшөөрөл хэн олгосон бэ?” гэх үгээ давтаад зогсохгүй, “Ер нь казах хэл гэж ямар хэл байдаг юм бэ?” гэж доромжилжээ. Мөн тэрээр тус радиогийнхныг “Монгол Улсын нутаг дэвсгэр дээр заавал казах хэлээр мэдээлэл цацах ямар эрхтэй юм. Цаашид мэдээ нийтлэлийнхээ агуулгыг мэдээлж бай” гэж шаардсан байна.

Дорнод аймгийн “Шинэ суваг” телевизийн захирал сэтгүүлч С.Дэлгэр тус аймагт өрнөж байсан аймгийн Засаг даргыг огцруулах Иргэний Зориг намын хөдөлгөөний тухай төлбөрт нэвтрүүлгийг хэд хэдэн удаа цацжээ. 2007 оны 5-р сарын 04-ний өдөр 23.30 минутын үед сэтгүүлч эмэгтэйг гэртээ ороход хаалганд нь “Ална шүү, амьсгаа минь” хэмээн заналхийлсэн зурвас хэвчүүлсэн байв. Мөн маргааш орой нь орчны ханан дээр шүршдэг будгаар эмэгтэй хүнийг илтэд бүдүүлгээр доромжлон нэр төрийг нь гутаах үг, өгүүлбэр бичиж үлдээсэн байв. Энэ тухай сэтгүүлч С.Дэлгэр аймгийнхаа Цагдаагийн газарт мэдээлсэн ч хариу үйлдэл хийгээгүй байна.

“Өдрийн сонин”-ы сэтгүүлч Л.Мөнхбаясгалан 2007 оны 06-р сарын 19-ний дугаарт “Онгоц хайх ёстой сайд нар У.Хүрэлсүхийн төрсөн өдрийн баярт танц гишгэж байжээ” нэртэй нийтлэлийг бичжээ. Нийтлэл гарсны орой буюу 10 цаг 28 минутад УИХ-ын гишүүн, Мэргэжлийн хяналтын асуудал эрхэлсэн дэд сайд У.Хүрэлсүх өөрийнхөө 99113937 дугаараас залган “Би Хүрэлсүх байна. Яагаад ийм хачин хачин юм бичээд байгаа юм бэ. Чи их олон долоон юм бичиж байгаа шүү. Би чамайг олон удаа өршөөсөн. Энэ удаа чадахгүй. Чамайг ална даа. Харж байгаарай” гэж заналхийлсэн байна. Сэтгүүлч Л.Мөнхбаясгалан тус нийтлэлдээ шүхэрчин, гал сөнөөгчид албан үүргээ гүйцэтгэж яваад осолдон амь тавьж байхад хариуцсан салбарын сайд дарга нар нь У.Хүрэлсүхийн төрсөн өдөрт найрлаж цаг алдсан зэргийг баримтаар дурджээ.

Дундговь аймгийн “Говийн амьдрал” сонины сурвалжлагч Б.Аасүрэнг тус аймгийн ЗДТГ-ын төрийн захиргааны хэлтсийн дарга Б.Энхтуяа 2007 оны 3-р сарын 13-ны өдөр өрөөндөө дуудаж: “Аймгийн оны шилдгүүдийн тухай мэдээлэл сонинд гараагүй, Аймгийн засаг даргын үйл ажиллагааг тодорхой гаргахгүй, төрийн мэдээлэл дутмаг байна” хэмээн загнажээ. Сурвалжлагч Б.Аасүрэнг дуудсан цагт нь ирээгүй, мөн “Би төрийн албан хаагч биш” гэж хэлснийх нь төлөө ийнхүү дуудаж “Эвгүй яривал эвгүй ярьж болно шүү дээ” хэмээн дарамталжээ.

УИХ-ын гишүүн, Үйлдвэр худалдааны сайд Б.Жаргалсайхан 2007 оны нэгдүгээр сарын 11-ний өдөр болсон хэвлэлийн бага хурлын үеэр телевизийн зураглаачид руу хандаж “Та нүүрэн дээр нааж зураг авлаа. Төрийн ордонд, төрийн түшээгийн өмнө эвгүй “поз”-оор зогслоо” хэмээн загнаж, ТВ5 телевизийн сэтгүүлчийн асуултанд хариулахгүй гээд, “Өдрийн сонин”-ыг

16 жил өөрийг нь доромжилсон, дугаар болгоноор чинь гаргаж ирнэ шүү” хэмээн загнажээ. Гайхшаа барсан сэтгүүлчид Б.Жаргалсайхан сайдын яриаг тасалж “Асгатын мөнгөний орд газрын лицензийн тухай асуух гэж оролдоход “Чиний наад асуулт чинь сэтгүүлч хүний асуулт биш байна” гээд үргэлжлүүлэн загнажээ. Аргаа барсан сэтгүүлчид хэвлэлийн бага хурлыг хаяж гарахад тэрээр хойноос нь харааж загнасаар үлдсэн байна.

Хөвсгөл аймгийн “Эрх чөлөө” сонины 2007 оны 03-р сарын 20-ны No 8 дугаарт сурвалжлагч Ж.Чимидцэрэн өөрт тохиолдсон явдалд тулгуурлан шүүгч Н.Сарангүний хүнд суртлын тухай “Аймгийн шүүхэд ардчилал байна уу” шүүмжлэлт материал бичиж, Ж.Бүрэнбэх нэрээр нийтлүүлжээ. Тус нийтлэлийн дагуу аймгийн ерөнхий шүүгч З. Хосбаяр, сум дундын ерөнхий шүүгч М.Нармандах нар “Эрх чөлөө” сонины эрхлэгч Ю.Гэрэлтуяаг өрөөндөө дуудаж, “Аймгийн шүүхийн нэр төрийг сэргээлгэж танай сониныг шүүхэд өгнө” хэмээн сүрдүүлсэн байна.



Мэдээлэл түгээснийх нь төлөө сэтгүүлчдийг буруутгах тохиолдол гол төлөв албан тушаалтнуудаас гарч байна. Ингэснээрээ тэд л, шударга бус, хариуцлагагүй үйлдлийг бусдаас илүү гаргадаг, товчхондоо өөрөө өөрийгөө л барьж өгч байгаа хэрэг юм. Мэдээллийн бодитой эх сурвалж олж авсан сэтгүүлчийг, нэр хүндээ сэргээлгэх нэрийдлээр шүүхэд өгч, их хэмжээний торгууль мөнгө нэхэх зэргээр сүрдүүлж, дарамтлах аргыг тэд хэрэглэсэн хэвээрээ байна.

Ө.Рагчаасүрэн, Дархан

Ерөнхийлөгчийн хэвлэлийн алба “Өдрийн сонин”-д гарсан нийтлэлүүдтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрх, нэр хүндэд хууль бусаар халдахгүй байхыг хатуу анхааруулж, уучлал гуйхыг шаардаж, эс тэгвээс шүүхэд хандах тухайгаа 2007 оны 1-р сарын 24-нд гаргасан мэдэгдэлдээ дурдсан байна. “Өдрийн сонин”-ы 1-р сарын 19-ний дугаарын “Н.Энхбаярын Улс төрийн өшөө авалт эхэллээ” нийтлэлд “Ерөнхийлөгч Н.Энхбаярыг Худалдаа хөгжлийн банкинд хувь эзэмшдэг. Түүний тойрон хүрээлэгчдийн мөнгө тус банкинд урсаж байсан. ХХБ-ны 61.5 хувийг тендерээр авсан компани өөрийн хувиа зарсан нь Ерөнхийлөгч хяналтаа алдахад хүрээд байгаа” тухай өгүүлжээ.

Улаанбаатар хотын Сонгинохайрхан дүүргийн Өнөр хороололд байрлах “Ялалт” зочид буудалд бүлэг этгээдүүд насанд хүрээгүй охидыг барьцаалан биеийг нь үнэлүүлж байсан тухай гэмт хэргийн хохирогч эмэгтэйн ярилцлага 2007 оны тавдугаар сарын 15-ны өдрийн “Ардчилал” сонины N°044 дугаарт нийтлэгджээ. Уг ярилцлагад Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газрын Өнөр хороолол дахь тасгийн цагдаа Б.Баатарсүрэнд хохирогч эмэгтэй гурван удаа хандаж мэдээлэл өгч, тусламж хүсэхэд “Өөрийг чинь хорино шүү” гэж айлган сүрдүүлж, албан үүргээ хөсөрдүүлсэн тухай өгүүлжээ. Үүний дагуу SBN телевизийн сурвалжлагч Б.Цэрэндолгор газар дээр нь очиж сурвалжлага бэлтгэн эфирт цацсан байна. Гэтэл Сонгинохайрхан дүүргийн Цагдаагийн газраас SBN телевизэд хандан “Та нар манай цагдааг яасан их муулдаг юм бэ? Бид тэртээ тэргүй нэр нь холбогдсон Б.Баатарсүрэнд арга хэмжээ авна. Дахиад бидний тухай ярьж болохгүй шүү” гэж хэд хэдэн удаа утасдсаны зэрэгцээ цагдаа Б.Баатарсүрэн нь “Ялалт” зочид буудлын эзний хамт SBN телевизийн байранд ирж удирдлагуудтай нь уулзан “Миний тухай бичсэн тэр сурвалжлагч хаана байна? Нэр төрийг минь гутаалаа” гэж зандарч загнасан

бол охид хүүхнүүдийг барьцаанд байлгасан зочид буудлын эзэн нь “Та нарын сурвалжлагаас болж манай буудлын орлого хаагдлаа” хэмээн дарамталсан байна.

Монголын төр, засгийн удирдлагад хятадын эрлийзүүд олноороо гарсан учраас тэдний эсрэг тэмцэл өрнүүлэх ёстой хэмээн “Даяар Монгол” хөдөлгөөний гүйцэтгэх захирал З.Эрдэнэбилэг хэвлэлийн бага хурал хийлгэж байх үедээ асуулт тавьсан ТВ5 телевизийн сурвалжлагч Д.Энхцэцэгийг “Чам шиг хятадын эрлийзийн асуултад хариулахгүй” хэмээн олон нийтийн өмнө илт доромжлон, гүтгэж сэтгүүлчийн нэр хүндэд нь халдсан байна.

Дархан–Уул аймгийн “ORKHON” ТВ–ийн сурвалжлагч Дамдинбазарын Мөнхтөрийг 2007 оны 11–р сарын 01–нд, тус аймгийн Дархан хотын Ус цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагааг сурвалжилж, гаднах задгай усан сангийн зургийг аваад буцах үед нь, харуул хамгаалалтын “Darkhan SB” компанийн хамгаалагч М.Батсүх кассетийг нь хураахаар машиных нь бүхээгт дур мэдэн орж үзлэг нэгжлэг хийжээ. Сурвалжлагч Д.Мөнхтөр нь, орон нутгийн “ЛХА” ТВ–ээр үйл ажиллагаа нь доголдолтой байгаа тухай 2007.10.19–нд мэдээлэгдсэн Ус цэвэрлэх байгууламжийн тухай ээлжит сурвалжлагаа бэлтгэхээр материал цуглуулж явжээ. Харуул М.Батсүх нь, ТВ–ийн машинд нь нэгжлэг хийж байхдаа “Та нар ус цэвэрлэх байгууламжийн усан сангийн зургийг надаас зөвшөөрөл авалгүй авсан учраас би кассетийг чинь хурааж авна” гэжээ. Уг усан сан нь гадуураа ямар ч хашаа, хамгаалалт, харуулгүй учраас хаанаас нь хэн ч зураг авах боломжтой юм байна. Харин Ус цэвэрлэх байгууламжийн үндсэн цех нь гадуураа хашаатай, үүдэнд нь “Darkhan SB” компани харуулын үүрэг гүйцэтгэдэг ажээ.



Хөвсгөл аймаг ардчиллын өлгий нутаг гэдэг утгаараа ч тэрүү хэвлэл мэдээллийн хэрэгсэл олонтой, олон ишт үзэл бодлын эх нутаг гэхэд болно. Манай аймагт хэвлэл мэдээллийн 11 байгууллагад 40 орчим хүн ажилладаг. Хөдөөгийн сэтгүүлчдийн эрхийг зөрчих явдал өдөр тутам тохиолддог хэдий ч сэтгүүлчид тэр бүрт хариу нөлөөлөл үзүүлээд миний эрх зөрчигдлөө гээд хашгираад байдаггүй. Зөвхөн үнэнийг мэдэж үнэнийг мэдээлэхийн төлөө бусдын адил ажлаа хийснийхээ төлөө бусдад хэл амаар доромжлуулах бол хөдөөд наад захын хэрэг. Орон нутгийн нэг онцлог нь жижиг газар бүгд бие биенээ таньж мэдэх учир үнэнийг мэдээлсэн сэтгүүлчийг бодлогоор хавчих, утсаар дарамтлах, хэн нэгнээр хэлүүлэх, сэтгүүлчийн ар гэр ойр төрлийнхөнд ажлын нөхцөл байдлаар нь дарамт үзүүлэх зэрэг явдал түгээмэл байдаг.

Хөвсгөл аймаг дахь мониторингч Ю.Гэрэлтуяа

“Зууны мэдээ” сонины фото сурвалжлагч Ч.Лодой 2007 оны 10–р сарын 29–ний өдөр Төрийн ордны гадна талбайд /баруун/ 00–54 УБЗ улсын дугаартай, НИССАН маркийн машины гэрэл зургийг авсан байна. Гэтэл төрийн ордны гадна талбайн хамгаалалтын ажилтан нь /Төрийн тусгай хамгаалалтын газрын/ фото сурвалжлагч Ч.Лодойг харуулын цэг рүү дагаж явахыг тушаан зургийн аппаратыг нь хураан авч, доторхи зургуудыг нь хүчээр устгаж сэтгүүлчийн эрх чөлөөнд ноцтойгоор халджээ. Фото сурвалжлагч Ч.Лодой яагаад ингэж устгаж байгааг нь асуухад тус хамгаалалтын ажилтан “Бусдын өмчийн зургийг авахыг хориглоно” гээд “Дахиж зураг авбал аппаратыг чинь хурааж авна” гэж сүрдүүлжээ.

Хөвсгөл аймгийн “Эрх чөлөө” сонины 2007 оны өдрийн 10–р сарын 10–ны өдрийн “Цоохор богц” буланд газрын асуудлын талаар шүүмжлэлт нийтлэл гарчээ. Гэтэл Хөвсгөл аймгийн

тамгын газрын дарга Ш.Янжиндулам “Нэр төрд ноцтой халдлаа” хэмээн буруушаан тухайн нийтлэл бичсэн сэтгүүлчийг биечлэн уулзуулахыг шаарджээ. Мөн “Буруу ташаа мэдээлэл цуглуулж, ард иргэдэд буруу мэдээлэл цацдаг. Төрийн ажил зааварчлах дуртай хариуцлагагүй сурвалжлагчиддаа хариуцлага тооцон мэдээллийг буруу ташаа бичсэн гэж дараагийн сониндоо засаж залруул” гэсэн тулган шаардах бичгийг тус сонины редакцид өгсөн байна.

2.3 Мэдээлэл өгөхөөс татгалзах нь

Төр нь иргэндээ үйлчилдэг, иргэнийхээ эрхийг хүндэтгэдэг ардчилсан нийгэмд төр, түүний байгууллагын үйл ажиллагаа, баримт бичиг мэдээлэл олон түмэнд нээлттэй, ил тод байх учиртай. Монголд мэдээллийн эрх чөлөөг зохицуулсан тусгай хууль байхгүй ч иргэд Үндсэн хуулиар баталгаажсан мэдээлэл олж авах, хайх, хүлээн авах, түгээх эрх, эрх чөлөөгөө чөлөөтэй эдлэх ёстой.

“Мэдээллийн эрх чөлөө нь хүний язгуур эрх бөгөөд НҮБ-аас эрхэмлэдэг хүний бусад эрхийн үндсэн хэмжүүр мөн” хэмээн НҮБ-ын Ерөнхийн ассемблейн анхдугаар чуулга уулзалтын 59-р тогтоолоор тунхаглан баталсан байдаг.

Олон нийтийн мэдээлэлтэй байх эрхийг хангадаг хэвлэл мэдээллийн хэрэгсэл, сэтгүүлчид мэдээлэл олж авахдаа байнга бэрхшээлтэй тулгарч байгаа нь олон нийтэд бодит мэдээлэл өгөх боломж байхгүй байгааг харуулж байна. Төрийн байгууллагын албан тушаалтан, албан хаагчид олон нийтийн санаа зовж буй, тэдний ашиг сонирхолд нийцэж буй мэдээллийг сэтгүүлчдэд өгөхөөс татгалзах нь манай оронд түгээмэл, хэвийн үзэгдэл болжээ.

Хувийн хэвшлийн эзэд, гадаадын хөрөнгө оруулалттай пүүс компани болон сайн дурын байгууллагууд мөн адил сэтгүүлчдэд мэдээлэл өгөхгүй тэднийг ажил үүргээ гүйцэтгэхэд нь саад учруулсаар байгаа хоёр жишээг дор дурьдав.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр зохион байгуулахаар төлөвлөж буй “Монголын үрс эцэг эхтэйгээ” сэдэвт өдөрлөгийн хүрээнд “Гэр бүлээс гадуурх орчинд байгаа болон хараа хяналтгүй хүүхдүүдийн хэрхэн яаж амьдарч байгаа талаар” Монгол Улсын УИХ, Хүүхдийн эрхийн үндэсний төв, Монголын Үндэсний Олон Нийтийн Телевиз, ТВ5 телевизтэй хамтран цуврал нийтлэл нэвтрүүлгүүд бэлтгэж байв. Энэ зорилгоор олон улсын асрамжийн газруудаар очиж мэдээлэл авах гэсэн МҮОНТ-ийн сэтгүүлч Ж.Алтангэрэл, ТВ5 телевизийн сэтгүүлч Д.Доржмаа нарыг бүдүүлгээр хөөж мэдээлэл өгөхөөс татгалзсан байна.

Америкийн хөрөнгө оруулалттай “Тереза эх” хүүхдийн асрамжийн төвийнхөн МҮОНТ-ийн сэтгүүлч Ж.Алтангэрэлийг дотогш оруулахгүй хоргоон “Хүүхдүүд сургуульдаа явсан, хэн ч байхгүй” гээд хаалгаа түгжжээ. Германы хөрөнгө оруулалттай хүүхдийн асрамжийн “Өгөөмөр” төвийн удирдлагууд сэтгүүлч Д. Доржмааг хаалгаараа түлхэн гаргаж, камерыг нь булаахыг оролдсон төдийгүй хоёр том нохойгоо хашаан дотроо суллан тавьсан байна.

“Өнөөдөр” сонины сэтгүүлч Г.Эрдэнэтуяа 2007 оны 2-р сарын 25-нд Улаанбаатараас 100 гаруй км зайд орших Төв аймгийн Борнуур суманд УИХ-ын гишүүн Ц.Батаа МИ-8 нисдэг тэргээр ан хийж яваад осолдсоныг сурвалжилж байхад хамгаалалтын цагдаагийн ажилтан зураг авахыг хоригложээ. Үүнээс нэг өдрийн дараа УИХ-ын гишүүн Ц.Батаа ослын талаар хийсэн хэвлэлийн бага хурал дээр “Боловсрол муутай сэтгүүлчид бидний ажлыг гуйвуулж байна” хэмээн мэдэгдсэн бол хожим нь тэрээр УИХ-ын чуулган дээр сэтгүүлчид рүү дайрч давшлан тэнэг мангуугаар нь дуудан хэл амаар доромжилж, “Төрийн ордонд оруулахгүй байх хэрэгтэй” хэмээн санал гаргажээ.

Нийслэлийн Баянгол дүүрэгт байрлах “Номин” их дэлгүүрийн шатнаас 2007 оны зургадугаар сарын 20-ны өдөр хоёр настай хүүхэд унаж нас баржээ. Үүний учрыг тодруулахаар сэтгүүлч, сурвалжлагчдыг очиход тус компанийн хамгаалалтын албаны ажилтнууд нь зураг авахуулахгүй,

мэдээлэл өгөхгүй гэж аппарат хэрэгслийг нь булааж авах гэж оролдсоноос “Ийгл” телевизийн зураглаач Д. Ууганбаатарын телекамерын дуранг хугалж гэмтээсэн байна.

2.4 Эх сурвалжаа илчлэхийг шаардах нь

Монголд шүүхээс өмнө, шүүх дээр сэтгүүлчдээс эх сурвалжаа илчлэхийг шаардах нь энгийн үзэгдэл юм. “Хэн энэ мэдээллийг өгсөн бэ?” гэдэг нь сэтгүүлчдийн бичсэн шүүмжлэлт материалд эмзэглэн гомдол мэдүүлэгч, түүнийг өмгөөлөгч, шүүгчдийн хамгийн эхний асуулт юм. Эх сурвалжаа илчлэхийг шаардаж буй хүмүүс гол төлөв цагдаа, шүүх, баривчлахаар айлгаж, сэтгүүлчдийг сүрдүүлэн мөн ар гэр, эрүүл мэндэд нь халдана гэж заналхийлдэг байна. Шүүхээс өмнө ийм төрлийн дарамтад өртсөн сэтгүүлчид энэ тухай мэдээлэхээс айдаг байна.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагаас нууц эх сурвалжтай харилцах хэлбэр, нууц эх сурвалжаа хамгаалахад тохиолдох саад бэрхшээл, түүнд эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлох заалтууд хэрхэн нөлөөлж байгааг үнэлэх зорилгоор мэдээ, нийгэм, улс төрийн чиглэлээр идэвхтэй ажилладаг 203 сэтгүүлчийг хамарсан судалгаа хийсэн юм. Судалгаанд 72 эрэгтэй, 131 эмэгтэй сэтгүүлч хамрагдсан. Судалгаанд хамрагдсан 203 сэтгүүлчийн 13 хувь нь нууц эх сурвалжийг тогтмол ашигладаг, 40 хувь нь нийтлэл/нэвтрүүлгийнхээ ихэнх хувьд нь ашигладаг, 43 хувь нь шаардлагатай үе, цөөн тохиолдолд ашигладаг ажээ. Харин сэтгүүлчдийн 4 хувь нь нууц эх сурвалжтай харьцдаггүй юм байна. Улаанбаатар хотын сэтгүүлчид хөдөө орон нутгийнхнийг бодвол нууц эх сурвалж ашиглалтаараа бараг 2 дахин их байна. Түүнчлэн сонины сэтгүүлчид бусад ХМХ-ийн сэтгүүлчдийг бодвол нууц эх сурвалжид түлхүү тулгуурладаг ажээ.

Нууц эх сурвалж ашигладаг 195 сэтгүүлчийн 45,6 хувь нь мэдээлэл ямар ч тохиолдолд найдвартай санагддаг, 43,1 хувь нь өөр аргаар мэдээлэл олж авах боломжгүй үед ашигладаг гэжээ.

195 сэтгүүлчийн 70 хувь нь нууц эх сурвалждаа амлалт өгдөггүй юм байна. Тэдний 52.3 хувь нь итгэлцлийн үндсэн дээр эх сурвалжтайгаа харилцдаг бол 12.8 хувь нь гэрээ хэлэлцээ хийдэг гэсэн байна.

Судалгаанд хамрагдсан сэтгүүлчдийн 38 хувь нь нууц эх сурвалжаа илчлэх албадлагад өртөж байжээ. Энэ нь Улаанбаатар хотод 37 хувь, орон нутагт 48 хувьтай байна. Тэдгээр 74 сэтгүүлчийн 39.4 хувьд цагдаа, 29.7 хувьд шүүх, 43.2 хувьд улс төрч, төрийн байгууллага, 10 хувьд тагнуулын ерөнхий газар, 35.2 хувьд хувь хүн, улс төрийн нам, хүчин нууц эх сурвалжаа илчлэхийг шаардаж байжээ. Мөн 6.8 хувьд нь ийм шаардлага төрийн бус байгууллага, олон улсын байгууллагаас тавьсан байна.

Эдгээр сэтгүүлчийн 23 хувь, өөрөөр хэлбэл 45 сэтгүүлч, тодруулбал 4 сэтгүүлч тутмын нэг нь мэдээллийнхээ нууц эх сурвалжийг илчилж байжээ. Тэдгээрийн ихэнх нь буюу 40.9 хувь нь шүүхийн шаардлагаар нууц эх сурвалжаа илчилж, шалтгааныг тэд аюулгүй байдлаа хангах (28.9%), шүүх байгууллагын шахалт, сүрдүүлэгт автаж (24.4%), ажлаасаа халагдахгүйн тулд (20%) мөн цөөн хувь нь шүүх байгууллагынхны эх сурвалжийг нууцлах үгэнд итгэж, шоронд хоригдох, ял эдлэхгүйн тулд зэргээр дурдсан байна.

Нууц эх сурвалжийн өгсөн мэдээллээс шалтгаалан сэтгүүлчдийн 29 хувь эрүүгийн хэрэг, иргэний маргаанд холбогдож байжээ.

Сэтгүүлчдийг нууц эх сурвалжийнхаа өгсөн мэдээлэлтэй холбогдуулан шүүх хуралд гэрчээр дууддаг практик байгаа нь судалгаагаар нотлогдов. Сэтгүүлчийн 15 хувь нь буюу 31 сэтгүүлч гэрчээр дуудагджээ.

Нууц эх сурвалжаа илчлэх албадлагад өртсөн хоёр жишээг дор дурдав.

Ховд аймгийн “Ховдын мэдээ” сонин мэдээллийн нууц эх сурвалжид тулгуурлан 6-р дунд сургуулийн захирал Д.Цэрэг шинээр ажилд орсон багш нараас 500.0 мянган төгрөгийн хахууль авсан тухай гурван удаа нийтэлжээ. Хожим нь энэ тухай материал өдөр дутмын “Зууны мэдээ” сонинд гарсан байна. Хахууль авсан, өгсөн аль алиныг нь илчилсэн энэхүү нийтлэл гарсны дараа хахууль өгсөн хэмээн нэр нь дурдагдсан нэр бүхий багш нар “Ховдын мэдээ” сонины редакц дээр ирж “Энэ мэдээллийг бичихээс өмнө бидэнд үзүүлэх ёстой. Таныг шүүхэд өгч нэрээ төрөө сэргээлгэнэ. Бичсэн эх сурвалжаа хэлэхгүй бол танай хаалганы дэргэд ирж жагсаж хэвтэнэ” гэж сүрдүүлэн одоохон эдгээр хүмүүсийг хахууль өгөөгүй гэж залруулга хий гэж шаардсан. Дараа нь захирал Х.Цэрэг сонины өрөөнд ирж “Улс орон даяар тараагддаг төвийн хэвлэлд цацагдлаа. Энэ мэдээллийг хэн өгсөн бэ?” гэж нууц эх сурвалжаа илчлэхийг шаардсан байна. Энэ хэргийг аймгийн цагдаагийн газар шалгаж байна.

2006 оны 11-р сарын 10-ны өдрийн 30 дугаарт “Дорнод” сонины дугаарт “Бүсгүйчүүдийг худалдах сүлжээний бизнес гаарч байна” гарчигтэй нийтлэлд “... Ерээд оны монголын миссээр тодорч, аймаг орон нутгийнхаа өнгө зүс нь болж явсан бүсгүй хүртэл саяхан харь хүний халуун өвөрт жаргаж байгаад тагтнаас шидүүлж тахир дутуу боллоо.” гэж бичсэнийг 1994 оны Монголын мисс тэмцээний зэс эрдэнийн өргөмжлөлт Г.Туул өөрийгөө хэмээн тодруулж нэр төрөө сэргээлгэхээр шүүхэд ханджээ. Ерээд онд Дорнод аймгаас Монголын мисс тэмцээнд орж өргөмжлөл хүртэж байсан нь ганц Г. Туул биш ба түүнээс гадна гурван эмэгтэй байдаг аж. Шүүх хурал дээр Г.Туулын өмгөөлөгч М.Энхтуяа “Дорнод” сонины эрхлэгч Б.Туяаг мэдээллийнхээ эх сурвалжийг хэлэхийг удаа дараа шахаж шаарджээ. Дорнод аймгийн Хэрлэн сумын шүүх уг нэхэмжлэлийг хянан үзэж, “Дорнод” сонины эрхлэгч Б.Туяаг нэр төр гутаах хэрэгт буруутган 2007 оны 09-р сарын 05-ны өдөр тус сонины эд хөрөнгийг битүүмжлэн хураасан байна.

2.5 Нэр төр, алдар хүнд, гүтгэлэг, доромжлолтой холбоотой хуулийг ашиглаж буй нь

Олон улс оронд хувь хүний нэр төрийг хамгаалах нь хувь хүнд чиглэгдсэн байдаг. Олон улсын хэм хэмжээ, эрх зүйгээр “Гүтгэлгийг эрүүгийн гэмт хэрэг гэж үзэх нь хүний нэр төрийг хамгаалахад онцын шаардлагагүй байдаг бөгөөд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг хязгаарладаг учраас хүлээн зөвшөөрөх боломжгүй” гэж үздэг. Олон улс оронд эрүүгийн хуулийн ийм заалтыг эрх мэдэлтэй албан тушаалтнууд хүмүүсийн шүүмжлэлийг хорьж хязгаарлах, маргааныг таслан зогсоохын тулд буруугаар ашигладаг. Үүнийг хүлээн зөвшөөрсний үндсэн дээр олон улсын шүүхүүд Засгийн газруудад хүний эрхийг хязгаарлахдаа эрүүгийн шийтгэл хүлээлгэхээс түдгэлзэхийг зөвлөдөг.

2000 оны 12-р сарын 1-нд НҮБ тунхаг гаргаж, “Үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө, мэдээллийн чөлөөт урсгал, санаа бодлын асуудал дэлхийн олон оронд хямралт байдалд байна. Энэ нь үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний явцад нь сэтгүүлч, бусад хүмүүс рүү дайрч давшлах (цензурдэх), гүтгэлэг, доромжлолын хатуу хуулиар хохироох гэсэн хоёр хэлбэрээр илэрч байна” гэсэн бөгөөд “Гишүүн орнууд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөний эрхийг үл хязгаарлах байдлыг хангахын тулд гүтгэлгийн эсрэг хуулиа эргэн нягталж, үүнийгээ олон улсын өмнө хүлээсэн үүрэгтээ нийцүүлэхийг” уриалсан байдаг.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын хуульчдын хийсэн судалгаагаар 2006 онд нэр төр, алдар хүнд, гүтгэлэг, доромжлолтой холбоотой 36 хэрэг шүүхээр шийдвэрлэгдсэн байна. Үүнээс иргэний 33, эрүүгийн гурван хэрэг байжээ. Эдгээр хэргийн 52.2 хувь нь улс төрч, өндөр албан тушаалтан, төрийн албан хаагч, төрийн байгууллагын нэхэмжлэлээр шийдвэрлэгджээ.

Эрүүгийн 3 хэргийн хоёрт нэхэмжлэгч нь УИХ-ын гишүүн, төрийн өндөр албан тушаалтан байна. Шүүхээр шийдвэрлэгдсэн хэргийн 9.6 хувьд сэтгүүлч, ХМХ ялалт байгуулж, 54.8 хувьд нь ялагдсан байна. Харин 35.4 хувьд хариуцагч, нэхэмжлэгч эвлэрчээ.

“Глоб Интернэшнл” ТББ-аас хот, хөдөөгийн 203 сэтгүүлчийн дунд явуулсан судалгаанаас үзэхэд, тэдгээрийн 25 хувь нь нийтлэл/нэвтрүүлгээрээ эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлох заалтуудтай тулгарч байсан байна. Энэ нь Улаанбаатар хотод 25 хувь, орон нутагт 27 хувьтай байна. Тэдгээр хэргийн 56 хувийг мөрдөн байцаах шатанд, 22 хувийг шүүх хурлаар, 6,1 хувийг прокурорын шатанд хэрэгсэхгүй болгосон бол 42.9 хувь нь шүүх хурлаар ял шийтгүүлжээ. Эдгээр хэргийн нэхэмжлэгчдийн 70.9 хувь нь улс төрч, төрийн албан тушаалтан, төрийн байгууллага байлаа.



...Би бичсэн материалынхаа төлөө 7 удаа эрүүгийн хэрэгт холбогдсон. 4 удаагийнхад нь “Глоб Интернэшнл” ТББ надад хууль зүйн зөвлөгөө өгч өмгөөлөл үзүүлж байсан. Өнөөдөр сэтгүүлчдийнхээ төлөө дуугардаг, тэднийг өмгөөлдөг, хараат бус хэвлэлийг хөгжүүлэхэд Глоб л зүтгэж байна.

“Өдрийн сонин”-ы тоймч Г.Дашрэнцэн

Эрүүгийн хуулийн 110, 111 дүгээр зүйлээр шийтгэгдсэн хоёр хэргийг дор дурдав.

Засгийн газрын хэвлэл мэдээллийн албаны дарга асан Н.Дэмбэрэл нь 2007 оны 3-р сарын 7-ны өдөр “25-р суваг” телевиз, NTV телевизүүдээр “Нүд улаан олигархууд” гэсэн төлбөрт нэвтрүүлэг явуулахдаа Монгол Улсын Ерөнхийлөгч Н.Энхбаяр, УИХ-ын гишүүн Ч.Улаан нарын талаар дурьдсан байна. Нэвтрүүлэгт “Н.Энхбаяр гэдэг хүн МАХН-ын дарга байхдаа нэг хүний дэглэм тогтоохыг оролдож ажилласаар ирсэн. Ерөнхийлөгч Н.Энхбаяр нь МАХН-ын доторх нөлөөгөө хадгалах гэж улайрах учир нь Ерөнхийлөгчийн дараагийн сонгуульд нэр дэвшиж ялах гэсэн бодол бөгөөд өөрөөр түүнд ард түмнийхээ төлөө бодож байгаа зүйл тун бага” хэмээсэн байна.

Үүний эсрэг УИХ-ын гишүүн Ч.Улаан нэр төрөө сэргээлгэхээр Эрүүгийн хуулийн гүтгэх, доромжлох зүйлээр нэхэмжлэл гаргаж 2007 оны 5-р сарын 1-ний өдөр Хэрэг бүртгэх газрын хэрэг бүртгэгч Цагдаагийн ахмад М.Ариунбаатар эрүүгийн хэрэг үүсгэн шалгаж эхэлжээ. Мөрдөн байцаалтын явцад Н.Дэмбэрэл нь 2007-06-29-ний өдөр сэжигтнээр тооцогдон байцаалт өгөхдөө 2007 оны 03-р сард тухайн нэвтрүүлгийг сонин хэвлэлд нийтлэгдсэн материалуудыг үндэслэж өөрөө бэлтгэсэн хэмээн мэдүүлжээ. “Өдрийн сонин” 2007 оны N°182-рт нийтлэгдсэн “У.Хүрэлсүх: Н.Энхбаяр хугацаанаасаа өмнө огцрох ёстой” гэх мэт 30 орчим нийтлэлийг нэвтрүүлэгтээ эх сурвалж болгон ашигласан нь хавтаст хэрэгт хавсрагдсан байна.

Энэ нэвтрүүлэгт нэр нь дурдагдсан Монгол Улсын ерөнхийлөгч түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч Д.Батсүх нь 2007-06-08-ний өдөр хүсэлт гаргаж, “Ерөнхийлөгчийн нэр төр, ажил хэргийн нэр хүндийг санаатайгаар гутаасан гэж үзэж байна. Иймд МУ-н ерөнхийлөгчийн хуулиар хамгаалагдсан халдашгүй дархан нэр төр, ажил хэргийн нэр хүндийг санаатайгаар гутаан гүтгэсэн мэдээлэл бүхий нэвтрүүлгийг бэлтгэсэн Н.Дэмбэрэлийн үйлдсэн хэргийг шалгаж өгөхийг хүссэн” өргөдөл гаргасан байна.

Дээрх хэрэгт 2007-05-01-ний өдөр эрүүгийн хэрэг үүсгэснийг прокурор И.Хүдэрцэцэг нь хянаж үзээд дээрх нийтлэлд Н.Дэмбэрэл нь Ч.Улааны нэр төр алдар хүндийг гутаан доромжилсон шинж, үг өгүүлбэр агуулгын хувьд байхгүй гэсэн үндэслэлээр эрүүгийн хэрэг үүсгэхээс татгалзан хэргийг хэрэгсэхгүй болгосон байна.

2007-05-30-ний өдөр хяналтын прокурор хянаж үзэн хэрэг бүртгэлтийн явцад шалгагдвал зохих зарим ажиллагааг шалгаагүй, дутуу шалгаж үндэслэлгүйгээр хэрэгсэхгүй болгосон гэж үзэн эрүүгийн хэрэг үүсгэн шалгажээ.

Уг хэргийн анхан шатны шүүх хурал 2007-08-31-ний өдөр СБД-ийн шүүхэд болж Н.Дэмбэрэлийг эрүүгийн хуулийн 110-р зүйлийн 1-дэх хэсэг, 111-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар яллагдагчаар татаж хянан хэлэлцээд шүүгдэгч Н.Дэмбэрэлийг бусдыг доромжлох, гүтгэх гэмт хэргийг үйлдсэн гэм буруутайд тооцож эрүүгийн хуулийн тусгай ангийн 110-р зүйлийн 1-дэх хэсэгт зааснаар нэг сар баривчлах ялаар, мөн хуулийн 111-р зүйлийн 2 дахь хэсэгт зааснаар дөрвөн сар баривчлах ялаар шийтгэж эрүүгийн хуулийн ерөнхий ангийн 57-р зүйлийн 1-д зааснаар Н.Дэмбэрэлд оногдуулсан хөнгөн ялыг хүндэд багтаан биечлэн эдлэх ялыг дөрвөн сар баривчлах ялаар тогтоов.

2007-09-10-ний өдөр Н.Дэмбэрэлийн өмгөөлөгч М.Алтан-Өлзий нь дээд шатны шүүхэд бичсэн гомдолдоо “хууль зүйн үүднээс бодитойгоор дүгнэлт хийвэл Н.Дэмбэрэлийн үйлдэлд эрүүгийн хуулийн 110-р зүйлийн 1-д заасан “Бусдын нэр төр алдар хүндийг доромжилсон”, 111-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан “хүний нэр төр, алдар хүндийг гутаах зорилгоор илт худал гүтгэсэн” гэмт хэргийн бүрэлдэхүүн байхгүй тул хэргийг хэрэгсэхгүй болгож өгөхийг хүссэн байна.

2007-10-14-ний өдөр нийслэлийн шүүх уг хэргийг хянаад СБД-ийн шүүхийн 2007 оны 8 дугаар сарын 31-ний өдрийн 267 тоот шийтгэх тогтоолын тогтоох хэсгийн заалтанд шүүгдэгч Н.Дэмбэрэлийг эрүүгийн хуулийн 110-р зүйлийн 1-дэх хэсэгт заасан 1 сар баривчлах ялыг 2070000 төгрөгөөр торгох, эрүүгийн хуулийн 111-р зүйлийн 2 дахь хэсэгт заасан 4 сар баривчлах ялыг 6900000 төгрөгөөр торгож шийтгэсүгэй гэж өөрчилсөн байна.

Хэргийн материалаас харахад Н.Дэмбэрэл нь дээрх үйлдлийг хэн нэгнийг гүтгэх зорилгоор бус харин өдөр тутмын сонинуудын нийтлэлийн хүрээнд хийсэн гэдэг нь нотлогдсон байхад эрүүгийн хариуцлага хүлээлгэсэн нь буруу юм.

“Зууны мэдээ” сонины сэтгүүлч Б.Цогнэмэхийн бичсэн УИХ-ын гишүүн төсвийн байнгын хорооны дарга Ч.Улааны талаар “Зууны мэдээ” сонины 2006-09-22-ний өдрийн 228 дугаарт “Ялааны алуур”, мөн сонины 2007-02-05-ны 19 дүгээрт “Увиагүй Ч.Улааны шинэ атак эхэлжээ”, мөн сонины 2007-03-05-ны өдрийн 54 дугаарт “Ч.Улааны урт гар Х.Баатарыг дахин амилуулав” гарчигтай нийтлэлүүд хэвлэгджээ. Эдгээр нийтлэлтэй холбоотойгоор УИХ-ын гишүүн, төсвийн байнгын хорооны дарга Ч.Улаан нэр төр, ажил хэргийн нэр хүндээ сэргээлгэхээр өргөдөл гаргасны дагуу 2007-04-09-ний өдөр хэрэг бүртгэх газрын хэрэг бүртгэгч цагдаагийн ахмад М.Ариунбаатар эрүүгийн хуулийн 110, 111-р зүйлд заасан гэмт хэрэг үйлдсэн гэж үзэн эрүүгийн хэрэг үүсгэсэн бөгөөд Б.Цогнэмэхийг шалгаж байх явцдаа эрхлэгч Б.Ганболдыг яллагдагчаар нэмж татсан байна.

“Зууны мэдээ” сонины эрхлэгч Б.Ганболдоос авсан тайлбарт “манай сонин 2007 онд авилгатай тэмцэх, “төрөөс төрсөн тэрбумтан”-ыг тодруулах чиглэлээр бодлогоо тодорхойлсон юм. Үүний нэг нь Ч.Улаан байсан юм” гэсэн байв. Мөн “сэтгүүлчид мэдээлэл олж авах боломж байдаг ч түүний нотлох баримтыг олж авахад бэрхшээлтэй байдаг. Ийм асуудлыг хэвлэл мэдээлэлээр хөндөж дараа нь хуулийн байгууллагаар шалгуулах замаар авилгатай тэмцэх ганцхан боломж сэтгүүлчдэд байдаг. Өөр хууль эрх зүйн зохицуулалт алга байна” гэсэн байна.



2002 онд шинээр батлагдсан Эрүүгийн хуулийн гүтгэлэг, доромжлолтой холбоотой хоёр заалтыг хасахыг сэтгүүлчид бид нэгэн дуугаар хүсч байгаа билээ. УИХ-ын гишүүн Ч.Улаан энэ заалтаар дулдуйдан сэтгүүлч намайг эрүүгийн хэрэгт татан байцаалгаж, өөрийн луйвраа халхлахыг оролдож, сүрдүүлж байв. Бид шантраагүй. Эрх мэдэлтнүүд үүнийг буруугаар тайлбарлаж, өөрт ашигтайгаар эргүүлж буй нь шударга ёсонд нийцнэ гэж үү. Намайг өмгөөлж хамгаалсан хэвлэл мэдээллийн бүх салбарынханд одоо ч талархаж явдаг юм. Энэ нь Цогнэмэхийг өмгөөлж хамгаалаад байгаа хэрэг бус, хэвлэлийн эрх чөлөө бодитой, тэнцвэртэйгээр оршин тогтнохыг нь хамгаалж буй хэрэг гэдгийг эрх мэдэлтнүүд ойлгоогүй.

“Зууны шуудан” сонины Нийгэм, гадаад мэдээллийн албаны дарга, сэтгүүлч Б.Цогнэмэх

2007-06-06-ний өдөр Б.Цогнэмэх, Б.Ганболд нарт холбогдох эрүүгийн хэргийг хяналтын прокурорхянаж “алдархүндийг гүтгэх зорилгоор гүтгэсэн гэх үйлдэл нь хангалттай нотлогдоогүй” тул эрүүгийн хуулийн 111-р зүйлд заасан гэмт хэргийг хэрэгсэхгүй болгосон. Харин УИХ-ын гишүүн төсвийн байнгын хорооны дарга Ч.Улааныг хэвлэл мэдээллийн хэрэгслээр доромжилсон болох нь тогтоогдсон гэж үзсэн боловч 2007-06-05-ны өдөр хохирогч Ч.Улааны хүсэлтээр уг хэргийг хэрэгсэхгүй болгосон байна. Хохирогч Ч.Улаан нь сэтгүүлч Б.Цогнэмэхтэй эвлэрсэн гэх бөгөөд Б.Ганболдтой холбоотой хэргийг иргэний журмаар шийдвэрлүүлэх хүсэлтэй гэсэн байна.



Гурав. Хэвлэл мэдээллийн өмчлөл

Монгол Улсад хэвлэл мэдээллийн өмчлөл, ил тод байдал, хэвлэл мэдээллийн төвлөрөл, гадаадын хөрөнгө оруулалт бүхий, мөн өргөн нэвтрүүлгийн үйл ажиллагааг зохицуулсан хууль тогтоомж байхгүй тухай эхний бүлэгт дурдсан. Хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл нь хэвлэл мэдээлэл, сэтгүүл зүйн чанарт зүй ёсоор нөлөөлдөг.

Өнөө хэр төрийн мэдэлд байгаа хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь Монгол дахь цорын ганц мэдээллийн агентлаг болох МОНЦАМЭ юм. Монгол Улсын Ерөнхий сайдын эрхлэх ажлын хүрээнд ажиллаж буй Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг МОНЦАМЭ-г 2005 оны 12-р сарын 15-нд болсон Монгол Улсын Засгийн газрын ээлжит хуралдаанаар Гадаад Хэргийн яамны дэргэдэх Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг болгон өөрчлөх саналыг дэмжиж, Гадаад хэргийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд харьяалуулан одоогийн орон тоо, зардлын хамт шилжүүлэх талаар Улсын Их хурлаар хэлэлцүүлэхээр тогтжээ. Гэвч МОНЦАМЭ агентлагийн статусын асуудлын талаар өнөө хэр ямар нэг шийдвэр гараагүй байна.

Монголд үйл ажиллагаа явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай цорын ганц хэвлэл мэдээллийн хэрэгсэл нь АНУ-ын И-Би-Си буюу Ийгл телевиз бөгөөд хоёр жил завсарласны дараа 2004 онд үйл ажиллагаагаа сэргээсэн мэдээллийн дагнасан суваг юм. Сүүлийн үед Монголд идэвхтэй өрнөж буй иргэдийн тэмцлийг өргөн сурвалжилж, үзэгчдийн санаа бодлыг шууд нэвтрүүлдэг.

Сүүлийн жилүүдэд байгуулагдсан ХМХ, тухайлбал радио телевизийн цаана нөлөө бүхий улс төрч, бизнес эрхлэгчид байгаа тухай олон нийтийн дунд янз бүрийн таавар байдаг. Өргөн нэвтрүүлгийн 73 хэрэгслийн 63.5 хувь нь хувийн эзэмшилд байгаа юм.

Ц.Нямдорж

Хэвлэл мэдээллийн хэрэгсэл рүү сарвуугаа хэт шургуулж байгаа нөхдийг би ойлгодоггүй. Шинэ телевизүүдийн ард дандаа улс төрчид байдаг юм билээ. Хувийнхаа нөлөөг нийгэмд хэвлэл мэдээллээр дамжуулан тогтоох гэж байгаа бол утгагүй хэрэг. Монголд хувийн 3-4 телевиз байхад л хангалттай. Хятадад 5-6 л байдаг шүү дээ

Эх сурвалж: “Өнөөдөр” сонин, №228(2882), 2006.09.29

Гэвч хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хөрөнгө оруулсан тухайгаа ил тод зарласан хүн одоохондоо Монгол Улсын Ерөнхийлөгчөөс өөр байхгүй. Тэрээр “25-р суваг” телевиз, “Өнөөдөр” сонины 2006 оны 5-р сарын 5-ны 104/2758-рт өгсөн ярилцлагадаа Буддын шашны Гандан хийдийн хамба лам Д.Чойцамц, тэр хоёрт Японы Агун шү гэдэг шашны байгууллага буддын шашны ёслолын үеэр телевизийн студи бэлэглэсэн, телевизийн сувгийн зөвшөөрөлтэй УИХ-ын гишүүн Ц. Мөнх-Оргилтой хамтран ТВ9 телевиз байгуулснаа хүлээн зөвшөөрсөн байдаг.

Төрийн өндөр албан тушаалтны 2007 оны Хөрөнгө орлогын мэдүүлгийг “Зууны мэдээ” сонины 2007.07.31–ээс 2007.08.05 дугааруудад нийтлэгдсэнээр авч үзэхэд, Монгол Улсын

Ерөнхийлөгчөөс аймгийн иргэдийн хурлын дарга хүртэлх нийт 220 төрийн өндөр албан тушаалтан хөрөнгө орлогоо мэдүүлжээ. Үүнд хэвлэл мэдээллийн хэрэгслийг үүсгэн байгуулсан, хувь оруулсан, худалдан авсан, хувьцаа эзэмшдэг гэсэн мэдээлэл алга байна.

“Глоб Интернэшнл” төрийн бус байгууллага өргөн нэвтрүүлгийн 74 хэрэгслийн өмчлөл, зохион байгуулалтад судалгаа хийсэн юм. Үүнд: Улаанбаатар хотын 31, хөдөө орон нутгийн 43 радио, телевизийг хамруулав. Радио, телевизийн 21 хувь нь кабель, 51 хувь нь газрын дамжуулах, 20 хувь нь сансрын дамжуулах станц, богино долгион, хиймэл дагуул ашиглаж байна.

Судалгаанд хамрагдсан өргөн нэвтрүүлгийн хэрэгслийн 37 хувь нь хувь хүний, 32 хувь нь хувийн өмчит байгууллагын санаачилгаар, 10.8 хувь нь төрийн бус байгууллага, 8.1 хувь нь олон улсын байгууллагын тусламжтай байгуулагдсан байна. Өмчийн хэлбэрийг авч үзвэл 63.5 хувь нь хязгаарлагдмал хариуцлагатай компани, 18 хувь олон нийтийн, 12.2 хувь нь төрийн бус байгууллагын, 2.7 хувь нь төрийн өмч ажээ. Үлдсэн хувь нь бусад хэлбэрийн өмчтэй гэсэн байна. ХМХ-ийн удирдлагын бүтцийг тодруулахад 52.7 хувь нь хүн, 28.4 хувь нь удирдах зөвлөл, 14.8 хувь төлөөлөн удирдах зөвлөл, 4.1 хувийг нь тодорхой байгууллага удирддаг гэсэн байна.

2007 онд ХМХ-ээр хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл, редакцийн хараат бус байдалтай холбоотой сонирхолтой маргаан өрнөсөн юм. Үүнд хийсэн агуулгын задлан шинжилгээний тайлангаас товч өгүүлье.

Агуулгын задлан шинжилгээг 2007.07.25-аас 2007.10.01-ний хооронд өдөр дутмын 9 сонинд нийтлэгдсэн ерөнхийлөгч Н.Энхбаяр, УИХ-ын гишүүн У.Хүрэлсүх нарын маргаантай холбоотой нийт 28 материалд хийсэн юм.

Энэхүү маргаан МАХН-ын бүлгийн 2007.07.23-ны өдрийн хуралдаан дээр УИХ-ын гишүүн У.Хүрэлсүх: “Ерөнхийлөгч Н.Энхбаяр шоронд сууж байх ёстой хүн” гэж хэлснээр эхэлжээ. Үүний дараа У.Хүрэлсүх 2007.08.01-нд “Монгол Улсын ерөнхийлөгчид хандсан ил захидлыг өдөр дутмын сонинуудад гаргасан. Энэ мэдэгдлийн хариуд МУ-ын ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч У.Хүрэлсүхэд хандан мэдэгдэл гаргасан. Үүнтэй холбогдуулан Үндсэний “Соёмбо” хөдөлгөөн мэдэгдэл гаргажээ.

УИХ-ын гишүүн У.Хүрэлсүх ил захидалдаа “ТВ9 телевиз, “Зууны мэдээ” сонин, Н.Энхбаяр, түүний эхнэр О.Цолмонгийн хувийн өмч. Үүнийг эхнэрийн хамаатан улсын заан Ганболдын дүүгийн нэрээр авсан, тэдгээр байгууллагын бодлого, чиглэлийг дээрээс удирдаж байдаг” хэмээн мэдэгдэж, дараахь асуултыг тавьжээ.

- ТВ9 телевиз, “Зууны мэдээ” сониноор хүмүүсийг гүтгэн гүжирдэж, доромжилж, нэр төрд нь халдаж байгаа нь таны байр суурь мөн үү?
- ТВ9 телевиз, “Зууны мэдээ” сонин таны гэр бүлийн хувийн өмч мөн бол ямар арга замаар олж авсанаа олон нийтэд тайлбарлах
- “Зууны мэдээ” сонинд “Ард түмэн МАХН-гүйгээр төр барих эрхээ эдэлж болно” гэж бичсэн нийтлэл таны хувийн хэвлэлд гарчээ. Энэ нь МАХН-ын намын олон мянган гишүүдийн дургүйцлийг төрүүлж байна гэх мэт асуудлыг тавьсан байна.

У.Хүрэлсүхийн мэдэгдлийн эсрэг “Зууны мэдээ” сонины сэтгүүлчид 2007.07.25 болон 2007.08.01-ний “Сэтгэхүйн цагдаа У.Хүрэлсүх танаа” гэсэн хариу мэдэгдэлдээ: “Зууны мэдээ” сонин улс төрчдийн бус иргэний, улс төрийн намуудын бус олон нийтийн эрх ашгийг хамгаалж, иргэний нийгмийн чөлөөт индэр байх болно гэдгээ тов тодорхой хэлсэн гээд...

Агуулгын задлан шинжилгээнд дурдсан нийт мэдээллийн 46,4% нь батлаагүй боловч өмч нь мөн гэж дурьдсан, 14,4% нь үүнийг үгүйсгэсэн, 39,2% нь энэ асуудлын талаар дурьдаагүй байна.

У.Хүрэлсүхийн энэ мэдэгдлийн эсрэг Монгол Улсын ерөнхийлөгчийн хэвлэлийн төлөөлөгч хариу мэдэгдэл хийхдээ “Зууны мэдээ” сонин, ТВ9 телевизийг ерөнхийлөгч Н.Энхбаяр байгуулалцаж байснаа хэнээс ч нуугаагүй бөгөөд ТВ9 телевиз, “Зууны мэдээ” сонин нь хуулийн дагуу байгуулагдаж, хуулийн хүрээнд үйл ажиллагаа явуулж байгаа бие даасан мэдээлэл, нийтлэлийн бодлоготой хэвлэл мэдээллийн хэрэгслүүд бөгөөд ерөнхийлөгч Н.Энхбаярын хувийн өмч биш” юм гэсэн тайлбарыг хийсэн.

У.Хүрэлсүхийн МАХН-ын 2007.07.23-ны өдрийн хуралдаан дээр хэлсэн үгийг хуучин спикер Ц.Нямдорж дэмжиж, “Энхбаяр үүнийг хийлгэж байгаа нь үнэн. Монгол банкны Чулуунбаттай нийлж луйвар хийдэг. Би ерөнхийлөгчийг хэвлэл мэдээлэл атгаж байдаг хэмээн хэлж байсан нь батлагдаж байна. Засгийн газар, сайдуудын талаар Ерөнхийлөгч өөрөө хэлж сониндоо бичүүлдэг” гэж хэлсэн байна.

Үндэсний “Соёмбо” хөдөлгөөн У.Хүрэлсүхийн мэдэгдлийг дэмжиж, ерөнхийлөгчид хандан гаргасан мэдэгдэлдээ (Өдрийн сонин 2007.08.10 №188) “Ерөнхийлөгч Н.Энхбаяр олон тэрбумын хөрөнгөтэй “ТВ-9” телевиз болон “Зууны мэдээ” зэрэг хувийн компаниудын хөрөнгийн эх үүсвэрээ хаанаас олсоноо ард нийтэд одоо болтол ил тод болгоогүй” гэж мэдэгдсэн байна. Мөн “Ардын эрх” сонины 2007.07.30-ны өдрийн №146-д гарсан нийтлэлд МАХН-ын бүлгийн ахлагч Д.Идэвхтэн У.Хүрэлсүхэд ерөнхийлөгч Н.Энхбаяраас уучлал гуйх үүргийг өгсөн гэсэн бол, ЗГХЭГ-ын дарга Су.Батболд Монгол улсын сайд У.Хүрэлсүхийн мэдэгдэл “Монгол Улсын Засгийн газрын байр суурь биш гээд төрийн тэргүүнээсээ уучлал гуйхыг шаардаж байна” гэжээ. Судалгааны материалын 85,6%-д нь гуравдагч этгээдийн байр суурийн талаар тусгагдаагүй, 14,4%-д нь тусгагдсан байна.

Эдгээр маргаан нь олон нийтийг төөрөгдүүлэхгүйн тулд ХМХ-ийн өмчлөл ил тод байх эрх зүйн орчин шаардлагатай, редакцийн хараат бус байдлыг баталгаажуулахын чухлыг харуулсан жишээ юм.



Дөрөв. Төрийн нууц мэдээлэл

Тайлангийн хугацаанд төрийн нууцыг задруулсан хэргээр сэтгүүлч шийтгэл хүлээсэн тохиолдол гараагүй байна

“Глоб Интернэшнл” Төрийн бус байгууллагын “иргэдийн мэдээлэл олж авах нөхцөл боломж” судалгааны баг төрийн нэр бүхий 13 байгууллагаас 15 төрлийн мэдээлэл олж авах хүсэлт гаргасан юм. Нийт 15 мэдээллээс 12 нь иргэнд нээлттэй байх ёстой, гурав нь төрийн нууц мэдээлэл байсан юм. Судалгааны үр дүнд төрийн байгууллагаас ердөө дөрвөн мэдээлэл олж авсан юм. Иргэдэд нээлттэй байх ёстой 12 мэдээллээс олж авсан гурав, хуулиар төрийн нууц гэж хамгаалагдсан гурван мэдээллийн нэг нь нээлттэй болсон байв.

Төрийн байгууллагууд нийт есөн мэдээлэл өгөхөөс татгалзсан ба төрийн нууц(6), байгууллагын нууц (1), иргэд танилцаж байсан практик байхгүй(1) гэсэн шалтгаан хэлжээ. Харин ямар ч шалтгаангүйгээр нэг мэдээллийг өгөхөөс татгалзсан байна. Мөн татгалзаагүй боловч “вэб сайтад бий” гэсэн мэдээлэл байхгүй байсан, судлаачдад төлбөртэй өгч болно, өндөр үнэтэй зэргээс үүдэн хоёр мэдээллийг олж авч чадсангүй.

Монголд энгийн иргэдийн мэдээлэл олж авах эрх туйлын хязгаарлагдмал байгааг судалгааны дүн харуулсан юм. Төрийн нууцтай холбоотой хуулиудаар иргэдэд нээлттэй байх ёстой энгийн мэдээллийг ч төрийн нууцын халхавч дор нууцалж байгаа нь харагдав. Мэдээлэлтэй байх эрх бүх иргэнд адил тэгш үйлчлэхгүй байна. Төрийн нууцтай холбоотой хуулиуд нь орчин үеийн хөгжлийн шаардлагад нийцэхгүй, ардчилал, хүний эрхийн мөн чанар, зарчмуудад харшилж байгаа тул нэн даруй өөрчлөх шаардлагатай нь харагдсан билээ.

Дээрх дүгнэлтийг “Глоб Интернэшнл” төрийн бус байгууллагын дор дурдсан агуулгын задлан шинжилгээгээр дахин нотолж болно.

2007 оны 10-р сарын 17-ноос 10-р сарын 31-нийг хүртэлх хугацаанд “Ардын эрх”, “Зууны мэдээ”, “Зууны шуудан”, “Монголын мэдээ”, “Нийгмийн толь”, “Өдрийн сонин”, “Өнөөдөр”, “Өнөөдрийн Монгол”, “Улаанбаатар таймс”, “Үнэн” зэрэг өдөр тутмын 10 сонинд Монгол банктай холбоотой дуулиант материалууд нийтлэгдсэн юм.

Энэ дуулиан 2007 оны 10-р сарын 16-нд УИХ-ын эдийн засгийн байнгын хорооны хуралдаанаар Монголбанкны 2006 оны санхүүгийн тайланг хэлэлцэж, УИХ-аас томилсон ажлын хэсэг (ажлын хэсгийн ахлагч: УИХ-ын гишүүн Д.Ганхуяг, гишүүд: УИХ-ын гишүүн Ж.Батхуяг, УИХ-ын гишүүн М.Зоригт, УИХ-ын гишүүн Ч.Раднаа) Монголбанкны санхүүд хийсэн шалгалтын дүнг танилцуулах үед УИХ-ын гишүүн Батж.Батбаяр Монголбанкнаас ихээхэн хэмжээний мөнгө алга болсон тухай мэдэгдэл хийснээр эхэлжээ.

Төрийн нууцын тухай хууль, төрийн нууцын жагсаалтын тухай хуулийн зүйл заалт нийтэд ил болсон тухай асуудал хөндөгдсөн нь бидний анхаарлыг татаж байгаа юм. Тухайлбал, УИХ-ын ажлын хэсэг Монголбанкинд шалгалт хийсэн дүнг эдийн засгийн байнгын хорооны гишүүдэд нууцын зэрэглэлтэй гэсэн тодотголтой тараажээ. Ажлын хэсэг шалгалт хийх явцдаа шаардлагатай баримтын хуулбаруудыг Монголбанкны нууцын албаар дамжуулан авч үзсэн байна. Монголбанкны удирдлага ажлын хэсгийн дүгнэлтийг улсын нууцад хамаарах асуудал

гэж үзжээ. Монголбанкны Хуулийн хэлтсийн дарга Г.Эрдэнэбаярын хэлснээр “Валютын нөөц, мөнгөний нийлүүлэлттэй холбоотой баримтуудыг улсын нууцад хамааруулдаг” ажээ. Төрийн нууцын жагсаалт батлах тухай хуулийн 1.4-т “Гадаад орон, олон улсын байгууллагатай Монгол Улсын Засгийн газар, Төв банк санхүүгийн салбарт хамтран ажиллах болон өр, зээл, тусламжтай холбоотой гэрээ хэлэлцээрийн төсөл, тэдгээрийн боловсруулалтын шатанд хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйл, объект, үйл ажиллагаа” нууцад хамаарна гэж заасан байдаг.

Төрийн нууцтай холбоотой материалыг дэлгэх гэж буйг нь Д.Ганхуяг гишүүн анхааруулсан ч Б.Батбаяр гишүүн байнгын хорооны хаалттай хэлэлцэхээр төлөвлөж байсан ажлын хэсгийн тайланг дэлгэсэн байна. Шалгалтын дүнг Монголбанкныхан нууцад хамаарах учир ил хэлэлцэж болохгүй гэсэн ч энэ асуудлаар эдийн засгийн байнгын хорооны гишүүд санал хурааж, 13 гишүүний дийлэнх олонхийн (10) саналаар нээлттэй хэлэлцэх болжээ. Хамгийн сонирхолтой нь төрийн нууц гэгдсэн ажлын хэсгийн шалгалтын дүн нь “Зууны шуудан” сонины 2007 оны 10-р сарын 18-ны дугаарт “Улсын сан хөмрөгөөс алтны компанийн өрийг төлжээ” гарчигтайгаар бүрэн эхээрээ нийтлэгджээ.

Энэ нь төрийн нууцтай холбоотой хууль тогтоомжийн халхавч дор олон нийтийн эрх ашигт нийцсэн мэдээллийг нуун дарагдуулдагийн тод жишээ юм.



Тав. Монголын хэвлэл мэдээллийн салбар дахь анхны өлсгөлөн

Төрийн мэдлийн байсан өргөн нэвтрүүлэг олон нийтийн болох шилжилтийн явцад нэлээд хүндрэл бэрхшээлтэй тулгарч байна. 2005 оны 1-р сард шинээр байгуулагдсан Монголын Үндэсний Олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирлыг томилох үйл явцын үеэр эхэлсэн хамт олны тэмцэл хурцадсаар 2007 оны зургадугаар сарын 14-нөөс эхлэн суулт зарласан юм.



Тэмцлийн эхэн үед Түр хороо нэртэй байсан Хамт олны зөвлөл МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн 15 гишүүнийг томилохдоо урьдчилан шалгаруулалтад оролцоогүй зургаан хүнийг улс төрийн намуудын шахалтаар албан хүчээр УИХ-д оруулж батлуулсан, Үндэсний зөвлөлөөс радио, телевизийн дэд захирал, алба, нэгжийн дарга нарыг сонгохдоо сонгон шалгаруулах журмыг баримтлаагүй зэрэг нь хууль бус үйлдэл байсан тухай мэдэгдэж, тэмцлээ эхэлсэн. Хамт олны зөвлөлийн төлөөлөгч зургаан сэтгүүлч 2007 оны 7-р сарын 5-ны 11.00 цагаас эхлэн "гурван шатны шүүхийн шийдвэрийг Үндэсний зөвлөл хайхарч үзэлгүй, харин ч радио, телевизийн хамт олныг хяхан хавчиж, аттестатчилал нэрийн дор олон арваар нь халахыг санаархаж байна" гэсэн шалтгаанаар өлсгөлөн зарлах болсноо мэдэгдэн холбогдох газруудаас хуулийн дагуу зөвшөөрөл авахаар албан бичиг илгээсэн байна.

2007 оны 7-р сарын 6-ны 16.00 цагт эхэлсэн өлсгөлөн бүтэн гурав хоног үргэлжилж МҮЭ, "Глоб Интернэшнл" төрийн бус байгууллагын оролцоо, дэмжлэгтэйгээр явуулсан хэлэлцээрийн эцэст найман зүйл бүхий шаардлагыг Үндэсний зөвлөл хэрэгжүүлэхээр тохиролцож 2007 оны 7-р сарын 9-ний 21.00 цагт дээр эцэслэн буусан билээ.

Өлсгөлөнгийн үйл явцын товчооныг хавсралтаас үзнэ үү.



Зургаа. Дүгнэлт, цаашид яах вэ?

Монгол Улсад хэвлэлийн эрх чөлөөг хамгаалсан нааштай хууль тогтоомж байгаа хэдий ч амьдрал дээр хэвлэл мэдээллийн эрх чөлөө, сэтгүүлчдийн мэргэжлийн эрх зөрчигдсөөр байна. Сэтгүүлчийн мэргэжлийн эрх ийнхүү зөрчигдөх нь хэвлэл мэдээллийн эрх чөлөөг хязгаарлаж, сэтгүүлчид үнэн мэдээлэл түгээж чадахгүйд хүрч, ардчилал, нийгмийн эрх ашигт бодитой хор хохирол учруулна.

Монгол Улсад цагдан хяналт (цензур)–ыг хуулиар хориглосон ч ил болон далд хэлбэрээр байсаар байна. Хэвлэл мэдээллийн хэрэгсэлд хяналт тогтоож, сэтгүүлчдийн өөртөө үйлчлэхийг шаардах нь ардчиллын мөн чанар, хэм хэмжээ, зарчмаас гадуур үл тэвчиж болох үйлдэл юм.

Улс төрч, албан тушаалтан, албан хаагчид Эрүүгийн хууль, Иргэний хуулийн заалтуудыг цензур болгон ашиглах нь түгээмэл байна. Монголын шүүх нэр төр, гүтгэлэгтэй холбоотой хэргийг шийдвэрлэхдээ олон нийтийн үнэн мэдээлэлтэй байх хууль ёсны эрх ашгийг нь авч үзэлгүй өрөөсгөл хандаж байгаа нь шүүхийн шударга, хараат бус байдалд эргэлзээ төрүүлж байна.

Эрх баригчид өөрийн эрх мэдэл, албан тушаалыг ашиглан шударга шүүмжлэлийг няцаах, өөрсдийн буруутай үйлдлийг ард иргэдээс нуун дарагдуулахын тулд үнэн мэдээллийг саармагжуулах нь нийгмийн эрх ашигт ноцтой хор учруулна.

Монголын сэтгүүлчид өнөө хэр төрийн байгууллага, албан тушаалтан, албан хаагчдаас мэдээлэл олж авч чадахгүй, төрийн байгууллагын бичиг баримтыг олж үзэх боломжгүй байгаа нь төрийн байгууллагын олон нийтэд ил тод, нээлттэй байх ёстой ардчилсан зарчим алдагдаж, иргэдийн үнэн мэдээлэл олж авах эрх хөсөрдөхөд хүргэж байна. Энгийн мэдээлэл олж авах төдийд эрх нь зөрчигдөж буй сэтгүүлчид далд нуугдмал буй мэдээлэл, баримт мэдээг эрэн сурвалжилж олон түмэнд мэдээлэхэд туйлын хүндрэлтэй байгааг илтгэж байна.

Монголын хэвлэл мэдээллийн хэрэгслийн өмчлөл нийтэд ил тод бус байгаа нь олон ургальч үзлийг хөхиүлэн дэмжих бус, харин тэдгээрийн далд эздийн үзэл бодол, нэг талыг барьж туйлширсан мэдээллээ олон түмэнд тулган нийгмийг төөрөгдүүлэн будлихад хүргэж байна. Монголын олон нийт хэн нь үнэн ярьж байгааг ойлгохоо байж, хэвлэл мэдээлэл, сэтгүүлчдэд итгэл алдрах нь нийгмийн шударга ёсыг уландаа гишгиж буй хэрэг юм.

Сэтгүүлчид янз бүрийн дарамт шахалт дор эх сурвалжаа илчлэх нь мэдээлэгчдийн аюулгүй байдалд ноцтой хор учруулах төдийгүй хэвлэл мэдээлэл ард иргэдийн өмнө хүлээсэн хяналтын үүргээ хөсөрдүүлэхэд хүргэнэ. Эрэн сурвалжлах сэтгүүл зүйн ач холбогдол, үнэ цэнэ алга болбол нийгэм хэзээ ч цэвэршиж, ариусахгүй.

Үнэнийг хэлэх гэсэн, хэлснийх нь төлөө сэтгүүлчдийг дайрч давшлах, далайлган сүрдүүлэх, айлган занахийлэх, өмч хөрөнгө, бие эрхтэнд халдах нь хэрхэвч байж болохгүй ноцтой үйлдэл, гэмт хэрэг юм. Монголын цагдаа, шүүх буруутныг илрүүлэн үнэн мөнийг тогтоож, хариуцлага хүлээлгэх үүргээ зохих ёсоор биелүүлж чадахгүй байгаа нь харамсалтай.

Цаашид яах вэ?

Хэвлэлийн эрх чөлөө хэзээ ч зүгээр ирдэггүй. Үүнийг тэмцэж олдог.

- ✦ Нэгдүгээрт, хэвлэл мэдээлэл сэтгүүлчдийн эсрэг аливаа дайралтыг илрүүлэн баримтжуулж, олон нийтэд ил тод мэдээлэх нь чухал. Бид гагцхүү иргэний нийгмийн байгууллага, олон нийт, хэвлэл мэдээллийн хамтын нягт харилцаа, тэмцлийн дүнд ийм дайралтыг сөрөн зогсож чадна.
- ✦ Хоёрдугаарт, сэтгүүлчид өөрийн эрх зөрчигдөж буйг далдлан нууцлах нь үүнээс илүү уршигт үр дагавартайг ухамсарлан ойлгох нь чухал байна. Зөрчлийг илчилж байж нөхдийнхөө эрсдлийг бууруулна гэдгийг ойлгох нь зүйтэй.
- ✦ Гуравдугаарт, сэтгүүлчид өөрсдийн эсрэг дайралтыг эсэргүүцэн хүчээ нэгтгэж, эв нэгдэлтэй тэмцэх нь чухал юм. Гагцхүү эв нэгдэл биднийг өөрийн хөдөлмөрлөж буй нөхцөл, улс төр, эдийн засаг, эрх зүйн орчинг таатай болгох, эрх баригчдын дайралтыг эсэргүүцэн тэмцэхэд голлох үүрэг гүйцэтгэнэ. Хэвлэлийн эрх чөлөө нь Монголд үйл ажиллагаа явуулж буй сэтгүүлчдийн, хэвлэн нийтлэгчдийн эвлэл холбоодын гол эрх ашиг байх ёстой.
- ✦ Дөрөвдүгээрт, Монголд сэтгүүлчдийн эрх хэрхэн зөрчигдөж буйг дэлхий нийтэд мэдээлж, түгээх нь чухал. Гагцхүү дэлхийн хамтын нийгэмлэгийн дэмжлэг, донор, засгийн газар хоорондын, олон улсын хүний эрхийн байгууллагын хүчээр бид хэвлэлийн эрх чөлөөг илүү бодитой болгож чадна.



Хавсралт

Сэтгүүлчдийн зарласан өлсгөлөн

Долоодугаар сарын 5

13.00 – Хамт олны зөвлөлийнхөн өлсгөлөнгийн бэлтгэл ажилд орлоо.



14.00 – Өлсгөлөнд оролцох хүмүүсийн нэрс тодров.

15.00 – Холбогдох байгууллагуудад өлсгөлөн зарлах гэж байгаа талаар мэдэгдсэн захидал илгээв.

16.00 – Өлсгөлөнд оролцох уран бүтээлчид эмчийн үзлэгт хамрагдав

Долоодугаар сарын 6

11.00 – 16.00 – Эрүүл мэндийн үзлэгт оров.

16.00 – Өлсгөлөн эхлэв. "Бид шударга ёсыг хүснэ" уриатай өлсгөлөнд дөрвөн эрэгтэй, хоёр эмэгтэй уран бүтээлч оролцов.

18.00 – Өлсгөлөн зарлагчид байрлах гэрээ авчирч барилаа. Гадаа ширүүн бороотой байсан тул гэрийн шал, бүрээс бүгд норсон байв.



18.30 – Өлсгөлөн зарлаж эхэлснийг мэдмэгц “Глоб Интернэшнл” ТББ-ын тэргүүн Х.Наранжаргал сэтгүүлчийн хамт ирж өлсгөлөн нь хүчирхийллийн хэлбэр болох учир биед учруулах хор хохирлын тухай танилцуулав. Гэвч Үйлдвэрчний эвлэлийн дэргэдэх Хамт олны зөвлөл гаргасан шийдвэрээсээ ухрахгүй гэж шийдвэртэй мэдэгдсэн тул Х.Наранжаргал олон улсын хүний эрхийн байгууллагаас гаргасан өлсгөлөн зарлаж байгаа хүн юуг анхаарах талаар зөвлөмжүүдийг танилцуулав.

21.40 – Үндэсний зөвлөлийн ажлын хэсгийнхэн болох Х.Чилаажав, Л.Болд,

О.Эрдэнэ-Өлзий нар ирж өлсгөлөнгөө зогсоох талаар ятгав.

23.40 – “Глоб Интернэшнл” ТББ-ынхан тайван замаар тэмцлээ үргэлжүүлэхийг уриалав.

24.10 – Үндэсний зөвлөлийнхөн явцгаав

Долоодугаар сарын 7

15.00 – UBS, NTB, MYTB-ийн ММ агентлаг, ТВ5 телевизүүд ирж өлсгөлөнгийн явцын талаар мэдээлэл авлаа

16.00 – УИХ-ын дэд дарга Д.Идэвхтэн өлсгөлөн зарлаж байгаа уран бүтээлчидтэй уулзаж эрүүл мэнд, амь насанд халтай энэ аргыг сонгосны учрыг лавлахад, Хамт олны зөвлөлийн дарга Г.Бадамсамбуу “хөндлөнгийн хяналт, хамт олны оролцоо, иргэний хяналтын тогтолцоо хуулиар бүрдээгүй тул бид энд сууж байна. Хуулинд тийм зүйл заалт байсан бол бид тэр арга замаар нь тэмцэх байсан” гэж хэлэв.



Мөн МҮЭ-ийн холбооны төлөөлөгчид, Албан хаагчдын Олон Улсын ҮЭХ-ны Токио дахь төлөөлөгч Ито Ко Ичи нар ирж мэдээлэл солилцов. ҮЭ-ийн байгууллагын төлөөлөгчид өлсгөлөн зарлаж байгаа хүмүүст маш их хор хохиролтой үйлдэл хийж байгааг нь сануулж өлсгөлөнгөө зогсоох саналыг тавьж байв.

17.00 – МҮРадиогийн дарга Б.Пүрэвдаш, МҮТВ-ийн дарга Д.Мөнхбаатар, МҮТВ – ийн программын захиргааны дарга Ө.Нарангэрэл нар ирж уулзав.

18.00 – Үндэсний зөвлөлийн гишүүн Л.Төмөрбаатар, Г.Цэрэнпүрэв нар ирж өлсгөлөнг хурдан зогсоох талаар ярилцав. МҮОНРТ-ийн дарга М.Наранбаатар Үндэсний зөвлөлийнхөнтэй цуг ирсэн боловч өлсгөлөн зарлаж байгаа уран бүтээлчид уулзахаас татгалзав.

20.00 – “Глоб Интернэшнл” ТББ-ын тэргүүн Х.Наранжаргал өлсгөлөн зарлаж байгаа уран бүтээлчдээс биеийн байдал ямар байгааг лавлан Олон улсын чөлөөт илэрхийллийн сүлжээ болох IFEX-д Монголын сэтгүүлчид өлсгөлөн зарласан талаар мэдээлснээ танилцуулав. Өлсгөлөнгөө зогсоон тайван замаар тэмцэхийг дахин зөвлөв.



20.30 – Ахмадын чөлөөт холбоо, Иргэдийн шударга шүүх, мөн Сапу үйлдвэрийн хохирогчид өлсгөлөн зарлаж байгаа уран бүтээлчдийг дэмжиж байгаагаа илэрхийлсэн бичиг гардуулав

22.30 – МҮОНРТ-ийн дарга асан С.Мягмар ирж өлсгөлөн зарлаж байгаа уран бүтээлчидтэй уулзав.

Долоодугаар сарын 8

14.00 – NTV телевизийн шууд нэвтрүүлэгт Х.Наранжаргал, Хамт олны зөвлөлийн гишүүн Ө.Мөнх, Г.Бадамсамбуу, Б.Ганбаатар, нар оролцов.

17.00 – ТВ5 телевизийн “Бодлого” нэвтрүүлэгт Х.Наранжаргал, Хамт олны зөвлөлийн гишүүн Ө.Мөнх, Д.Байгалмаа, Алтанцэцэг нар оролцов. Тэнцвэртэй мэдээлэл өгөх үүднээс Үндэсний зөвлөлийн гишүүдээс урьсан боловч оролцроогүй.

18.00 – Өлсгөлөн зарласан хүмүүсийн биеийн байдал тааруу, ядарч сульдсан, даралт ихэссэн зэрэг өөрчлөлт гарч байгаа төдийгүй, гурван хүний суурь өвчин нь сэдэрч болзошгүй талаар эмч нар анхааруулав.



- 18.30 – Үндэсний зөвлөлийн гишүүн Ж.Занаа, Л.Дамдинсүрэн нар өлсгөлөн зарлагчидтай уулзан өлсгөлөнгөө зогсоохыг сануулав. .
- 21.40 – Х.Наранжаргал сэтгүүлчдийн биеийн байдал муудаж байгаад санаа зовж байгаагаа илэрхийлээд өлсгөлөнгөө яаралтай зогсоохыг дахин уриалав. Маргааш нь буюу долоодугаар сарын 9–ний өдрийн 11.00 цагаас ОНРТ–ийн баярын хуралтай болохыг мэдсэн Хамт олны зөвлөлийн гишүүд мэдээд ийм нөхцөл байдалд баярлаж байж яавч таарахгүй гэсэн дүгнэлтэд хүрэв. Мөн маргааш хэрхэх талаар ярилцав.
- 21.45 – “Хөх Монгол” бүлгийн 4 залуу ирж тэдний тэмцлийг дэмжиж байна, шаардлагатай бол хамтрахад бэлэн гэдгээ илэрхийлэв.
- 21.50 – МҮЭ–ийн холбооны ерөнхийлөгч С.Ганбаатар уулзаж, Хамт олны зөвлөлийг Ажилтан албан хаагчдын Үйлдвэрчний Эвлэлтэй хамтрахыг санал болгов.
- 23.30 – Үндэсний зөвлөлийн ажлын хэсгийн гишүүд Хамт олны зөвлөлтэй уулзах хүсэлт гаргасны дагуу Г.Бадамсамбуу, Ө.Мөнх, Б.Ганбаатар нар уулзахаар явав.
- 23.50 – Х.Наранжаргал Хамт олны зөвлөлийн гишүүдтэй зөвшилцсөний эцэст баярын хурлаас өмнө МҮОНРТ–ийн ажилчдыг цуглуулж нөхцөл байдлыг танилцуулах, маргаашийн дотор өлсгөлөнг зогсоох шаардлагатай гэсэн шийдэлд хүрэв.
- 23.55 – Үндэсний зөвлөлийн гишүүд О.Эрдэнэ–Өлзий, Л.Болд нар хүлээж байгаад явчихсан байсан тул хэлцэл хийхээр явсан гурав буцаж ирэв.

Долоодугаар сарын 9

- 10.00 – МҮОНРТ–ийн ажилтан, албан хаагчид өлсгөлөн зарласан уран бүтээлчдээ дэмжин цуглаан зохион байгуулав. Цуглаанд “Глоб Интернэшнл” ТББ–ын тэргүүн Х.Наранжаргал, МҮЭ–ийн холбооны ерөнхийлөгч С.Ганбаатар нар оролцож Хамт олны зөвлөлийнхөн, МҮОНРТ–ийн нийт ажилтан албан хаагчидтай санал бодлоо солилцож өлсгөлөнг яаралтай зогсоох шаардлагатайг уриалав. Өлсгөлөн зарлаж буй уран бүтээлчдийн шаардлагыг холбогдох эрх мэдэлтнүүдэд дамжуулахаар болов.



11.00 – МҮОНРТ-ийн ажилчид 5 минутын сануулах ажил хаялт зарлаж МҮОНРТ-ийн гадна өлсгөлөн зарлаад буй гэрийг тойрон тэдний үйл хэргийг сэтгэл санаагаараа дэмжиж байгаагаа илэрхийлсэн. Мөн 11.00 цагт эхлэх байсан МҮОНРТ-ийн баярын хурал хойшлов.



13.10 – О.Мэнд-Ооёо тэргүүтэй зохиолчид ирж тэдний тэмцлийг дэмжсэн мэдэгдэл гардуулав.

12.25 – МСНЭ-ийн ерөнхийлөгч Д.Сарангэрэл тэргүүлэгчидтэйгээ ирэв. Мөн УИХ-ын гишүүн Д.Дондог ирж өлсгөлөнгөө зогсоохыг санал болгов.



- 13.00 – УИХ-ын гишүүн Д.Дондог, МСНЭ-ийн ерөнхийлөгч Д.Сарангэрэл нар УИХ-ын дарга Д.Лүндээжанцантай уулзан “УИХ-аас Үндэсний зөвлөлийг яаралтай эргүүлэн татахыг шаардсан” боловч хуулинд тийм зүйл заалт байхгүй тул боломжгүй гэж хариу мэдэгдэв..
- 13.00 – Хамт олны зөвлөлийн төлөөлөгч Г.Бадамсамбуу, Д.Наранцэцэг, М.Баттөмөр, “Глоб Интернэшнл” ТББ-ын тэргүүн Х.Наранжаргал, МҮЭ-ийн холбооны ерөнхийлөгч С.Ганбаатар, МҮОНРТ-ийн Үндэсний зөвлөлийн дарга Х.Чилаажав, гишүүд Р.Бурмаа, Ж.Занаа, Г.Цэвээнпүрэв, Л.Болд нар өлсгөлөнг зогсоох зөвшилцөлд хүрэх ямар арга байгаа талаар хэлэлцэв. Х.Наранжаргал ЗО хэмийн халуунд хүмүүсийн биеийн байдал улам сульдаж, эрдэнэт хүний амь настай холбоотой асуудал яригдаж байгаа болохоор бүх бололцоогоо ашиглан өлсгөлөнг зогсоох хэрэгтэйг сануулав
- 17.40 – УИХ-ын Төрийн байгуулалтын байнгын хороо яаралтай хуралдаж Олон нийтийн радио, телевизийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг яаралтай боловсруулан УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх тогтоолыг батлав.
- 21.00 – “Глоб Интернэшнл” ТББ, МҮЭ-ийн холбооны хүчтэй лоббигоор бүтэн найман цаг үргэлжилсэн хэлэлцээрийн дүнд өлсгөлөн зарлаж буй уран бүтээлчдийн 8 зүйл бүхий шаардлагыг Үндэсний зөвлөл хэрэгжүүлэх зөвшилцөлд хүрснээр гурав хоног үргэлжилсэн өлсгөлөн 2007 оны долоодугаар 9-ний өдрийн 21.00 цагт зогсов.

